

Улсын бүртгэлийн дугаар:

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн ангилалын код:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШуСс 2018/34

“ДҮРСЛЭХ УРЛАГИЙН АКАДЕМИ” ДЭЭД СУРГУУЛЬ

“МОНГОЛ ЗУРГИЙН ХУВЬСАЛ, ХӨГЖЛИЙН СУДАЛГАА”

Суурь судалгааны төслийн тайлан

2018-2021

Төслийн удирдагч:

Б.Баяртөр, Доктор (Ph.D), профессор
“Дүрслэх урлагийн академи” дээд
сургуулийн ЭНБД

Санхүүжүүлэгч:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч:

Боловсрол шинжлэх ухааны яам

Тайланг өмчлөгч:

“Дүрслэх урлагийн академи” дээд
сургууль

Гүйцэтгэгч байгууллага:

“Дүрслэх урлагийн академи” дээд
сургууль

Улаанбаатар хот

2022 он

Улсын бүртгэлийн дугаар:

Нууцын зэрэглэл:

Аравтын бүрэн ангилалын код:

Төсөл хэрэгжүүлэх гэрээний
дугаар: ШуСс 2018/34

“ДҮРСЛЭХ УРЛАГИЙН АКАДЕМИ” ДЭЭД СУРГУУЛЬ

“МОНГОЛ ЗУРГИЙН ХУВЬСАЛ, ХӨГЖЛИЙН СУДАЛГАА”

Суурь судалгааны төслийн тайлан

2018-2021

Төслийн удирдагч:

Б.Баяртөр, Доктор (Ph.D), профессор
“Дүрслэх урлагийн академи” дээд
сургуулийн ЭНБД

Санхүүжүүлэгч:

Шинжлэх ухаан технологийн сан

Захиалагч:

Боловсрол шинжлэх ухааны яам

Тайланг өмчлөгч:

“Дүрслэх урлагийн академи” дээд
сургууль

Гүйцэтгэгч байгууллага:

“Дүрслэх урлагийн академи” дээд
сургууль

Улаанбаатар хот

2022 он

РЕФЕРАТ

Монголын үндэсний зураг дүрслэлийн гарал үүсэл нь хүй нэгдлийн үеийн болон монгол нутагт оршин байсан эртний төрт улс, аймаг, Эзэнт гүрний үеийн хийгээд Буддын соёл, урлагт холбогдохыг судалгаа шинжилгээний үр дүн харуулсаар байна. Харин бид “Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны хүрээнд монгол зургийн уламжлалт болон мэргэжлийн сургалт хийгээд XX зуунд монгол зураг хэрхэн хувьсан өөрчлөгдөж, хөгжлийн ямар түвшинд хүрэв, түүнд чухам ямар хүчин зүйл хэрхэн нөлөөлсөн болохыг холбогдох бүтээл туурвил, судалгаа шинжилгээний ном зохиолд тулгуурлан, шинжлэх ухааны онол арга зүйгээр тодруулахыг хичээсэн болно.

Тус төслийн үндсэн болон гэрээт гүйцэтгэгчид суурь судалгааны үр дүнгээр “XX зууны монгол зураг” эрдэм шинжилгээний ганц сэдэвт зохиолын эх бэлтгэж, монгол зургийн сургалтын загвар, зөвлөмж боловсруулж, магистрын зэрэг горилсон бүтээл бичиж, судалгааны илтгэл, өгүүлэл (хавсралт 1) хэвлүүлэв. Үүнд:

Нэг. “XX зууны монгол зураг” судалгааны бүтээлд: 1. Монголын үндэсний язгуур зураг дүрслэлийн үүсэл хөгжил, төрөл зүйл, уран сайхны сэтгэлгээний хэв маяг, монгол хүний байгаль, нийгмийн тухай үзэл төсөөллийг анхааран авч үзлээ. 2. XIX зууны сүүлч, XX зууны эхэн буюу Богд хаант Монгол улсын үед бүтээгдсэн монгол зургийн гол дурсгалууд, Хүрээ хийд, хот суурины зураг, Цагаан Жамба, Б.Шарав нарын бүтээлд тулгуурлан уламжлалт монгол зураг дахь байгаль, хүн, мал, амьтны дүр дүрслэлийн хэв маяг, адилтгал, зүйрлэл, ёгтлолын сэтгэлгээ, өнгө зохиомж, дүрс, зураасны онцлог тэргүүтэнг судлан тодруулахыг хичээсэн болно. 3. БНМАУ-ын төр, засгийн газрын зүгээс дүрслэх урлагийн талаар баримталсан бодлого, монгол зургийн мэргэжлийн сургалт, түүний үр дүнд үүсэн дэлгэрсэн “монгол зураг”-ийн шинэ хэв маяг, сэдэв, агуулгыг Д.Дамдинсүрэн, Ү.Ядамсүрэн, А.Сэнгэцохио нарын бүтээлд үндэслэн тодорхойлов. 4. XX зууны сүүлч буюу 1990-ээд оны үеийн монгол зургийн сэдэв, агуулга, төрөл зүйл, уран сайхны дүрслэл, илэрхийлэлийн онцлог юу байв, түүнд чухам ямар хүчин зүйл хэрхэн нөлөөлсөн болохыг холбогдох зураач, урчуудын гол бүтээл туурвил, эрдэмтэд, судлаачдын зохиолд тулгуурлан тодруулж, монгол зургийн хөгжлийн чиг хандлагын талаар үнэлэлт дүгнэлт өгч, санал дэвшүүлэв.

Хоёр. Төслийн үндсэн гүйцэтгэгч Г.Амарсанаа монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар, зөвлөмж боловсруулав.

Түүнчлэн доктор С.Бадрал монгол зургийн сургалтанд гарын авлага болгон ашиглаж болох “Монгол бэхэн зураг” (УБ., 2019) ном хэвлүүлээ.

Гурав. “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн магистрант О.Цацрал “Монгол зурагт эмэгтэйчүүдийг дүрслэх нь” (2018), Б.Хөхяргуй “Монгол зураг дахь натюрмортын дүрслэлийн зарим онцлог” (2019), А.Цэцэгмаа “Монгол зураг, бэхэн зургийн арга техникийг харьцуулан судлах нь” (2020), С.Хулан “Монгол зурагт ан амьтдыг дүрслэх нь” (2020), Б.Батцэцэг “Уламжлалт монгол зураг дахь амьтны дүр дүрслэлийн зарим онцлог” (2020) сэдвээр магистрын зэрэг горилсон бүтээл бичиж төгслөө.

Дөрөв. Төслийн хүрээнд “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, монголын зураач, урчууд, бурханч нарыг сурган бэлтгэж байсан уламжлал хийгээд монгол зургийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн цагаас өнөө хүртэлх үед хамрагдах монгол зургийн сургалтын бодлого, хөтөлбөр, заах арга барилыг харьцуулан судалж, санал, дүгнэлт дэвшүүлсэн 12 илтгэлийг сонсож хэлэлцлээ. (Илтгэлийн эмхэтгэл хэвлэгдсэн)

Тав. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурал цахимаар зохион байгуулж, монгол зургийн үүсэл хөгжил, монгол зургийн төрөл зүйл (ном судрын чимэг зураг, Перс-Монгол миниатюр зураг), монгол зургийн нэрт төлөөлөгч Д.Дамдинсүрэн, Б.Чинтогтох нарын амьдрал, түүх намтар, тэдгээрийн гол бүтээл туурвил, уламжлалт болон орчин үеийн монгол зургийн уран сайхны дүр дүрслэл, утга бэлгэдэл, зурж гүйцэтгэх арга ухаан, монгол зургийн хувьсал өөрчлөлт, цаашдын чиг хандлагын талаар шинэлэг санаа таамаглал дэвшүүлж, үнэлэлт дүгнэлт өгсөн 10-аад илтгэлийг сонсож хэлэлцлээ. (Илтгэлийн эмхэтгэл хэвлэгдсэн)

Зургаа. “Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” төслийн үндсэн болон гэрээт гүйцэтгэгчид “**төслийн үр дүнгийн даалгавар**” (хавсралт 2)-т тусгасан “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” (УБ., 2019), “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” (УБ., 2021) зэрэг эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл хэвлүүлж, монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар, зөвлөмж боловсруулж, “ХХ зууны монгол зураг” номын эх бэлтгэлээ.

Түлхүүр үг: Монгол зураг, бүтээл туурвил, дүр дүрслэл, өнгө, зохиомж, зураас

ГҮЙЦЭТГЭГЧДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ:

Амарсанаа Галмандахын. “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн ахлах багш, докторант. (Монгол зургийн сургалтын загвар, зөвлөмж боловсруулсан)

Бадрал Сүхбаатарын. “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн ахлах багш, доктор (Ph.D) Профессор (“Монгол бэхэн зураг” ном бичиж хэвлүүлсэн)

Баяртөр Балжиннямын. “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн ЭНБД, доктор (Ph.D) Профессор. (“ХХ зууны монгол зураг” ганц сэдэвт зохиол бичсэн)

Ням-Очир Оюунпүрэвийн. Чөлөөт уран бүтээлч, урлаг судлалын магистр. (материал эх хэрэглэгдэхүүн цуглуулж боловсруулсан)

Уранчимэг Доржсүрэнгийн. “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн захирал, доктор (Ph.D) Профессор. (Монгол зургийн судалгааны бүтээлийг англи, орос хэлээр орчуулсан)

ГАРЧИГ

ОРШИЛ	6
I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ШААРДЛАГА, СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ	9
II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	12
III. СУДАЛГААНЫ ОБЪЕКТ, ХАМРАХ ХҮРЭЭ	14
IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	
IV.1. “ХХ зууны монгол зураг” ганц сэдэвт бүтээл	15
IV.2. “Монгол зургийн сургалтын загвар, зөвлөмж”	20
V. ДҮГНЭЛТ	42
ХАВСРАЛТ 1. Судалгааны илтгэл, өгүүллийн жагсаалт	45
ХАВСРАЛТ 2. Холбогдох зураг	48
ХАВСРАЛТ 3. “ХХ зууны монгол зураг” бүтээлийн хэвлэлийн эх	53

ОРШИЛ

Монгол үндэстний уламжлалт өв соёл, зураг урлалын нэгэн томоохон төрөл МОНГОЛ ЗУРАГ-т монгол хүний уран сайхны сэтгэлгээ, урлан бүтээх арга ухаан, оюун санааны чадвар хурц тод илэрдэг билээ. Тийм учир монгол зургийн өнгө зохицол, зохиомж, зураас, дүр дүрслэл, түүгээр дамжин илрэх монголчуудын ертөнцийг үзэх үзэл, урлахуйн өв уламжлал, бэлгэдэлт сэтгэлгээг нарийвчлан судлах шаардлагатай. Өөрөөр хэлбэл өнөөгийн монголын нийгэм, эдийн засаг, урлаг, соёлын амьдралд гарч байгаа өөрчлөлт, шинэчлэлт, шинжлэх ухааны хөгжил дэвшлийн энэ эрин үед монголын зураг урлалын үүсэл хөгжил, хувьсал өөрчлөлт, язгуур хэв шинж, өвөрмөц онцлогийг нэхэн судлаж, шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлэлт дүгнэлт өгөх нь монгол үндэстний урлаг, соёлын талаарх үзэл баримтлал, ойлголтыг төлөвшүүлэх, монгол зургийн хосгүй үнэт өв дурсгал, бүтээл туурвилуудыг дахин үнэлэх боломжийг буй болгоход чухал ач холбогдолтой.

1990-ээд оноос өрнө, дорно дахины соёлын төрөл зүйл, урлагийн элдэв урсгал, чиглэл, хэв маяг монголын нийгэмд чөлөөтэй нэвтрэн дэлгэрч, улмаар язгуур өв соёлын хэлбэр, агуулга, урлан бүтээх арга ухаанд нөлөөлж байна. Ийм учир уламжлалт соёл, зураг урлагийг судлан сурталчлах, дархлааг сахин хамгаалах, дэмжин тэтгэх, хойч үедээ өвлүүлэн үлдээх асуудал Монгол Улсын Засгийн газрын бодлогод тусгагдсаар ирсэн юм. Үүний нэгэн жишээнд БСШУ-ны сайдын 2011 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 84 дүгээр тушаалаар баталсан “Монгол Улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэл”-ийн жагсаалтад “Монгол зургийн урлал” багтсаныг дурьдаж болно. Түүнчлэн “Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийг БСШУС-ын сайдын 2018 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн А/136 тоот тушаалаар батлан, захиалагч (БСШУСЯ), санхүүжүүлэгч (ШУТС), гүйцэтгэгч (ДДУС) гурван талын ШуСс 2018/34 гэрээний дагуу хэрэгжүүлэх боломжийг олгосон нь **Монгол зураг** судлалыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр болж байгааг цохон тэмдэглэж байна. Суурь судалгааны үр дүнд монгол зураг судлалын шинжлэх ухааны мэдлэг, онол арга зүй хөгжиж, урлаг судлаачид, багш нар, ахисан түвшний оюутны судалгааны дадлага туршлага өсөх үндэс суурь тавигдлаа гэж үзэж байна.

“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн арга зүй, календарчилсан төлөвлөгөөг боловсруулан батлуулж (СУИС-ийн ДДУС-ийн Эрдмийн зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 24) тус арга зүй, төлөвлөгөөний дагуу судалгааг гүйцэтгэлээ. Үүнд: төсөлд үндсэн болон гэрээт хэлбэрээр оролцогчидтой ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, судалгаанд холбогдох материал, эх хэрэглэгдэхүүн цуглуулан боловсруулж, үр дүнг эрдэм шинжилгээний ганц сэдэвт бүтээл, илтгэл, өгүүлэл хэлбэрээр бичиж, “Суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх гэрээ”- (**ШуСс 2018/34**) ны 1-р хавсралт дахь “Төслийн үр дүнгийн даалгавар”-т тусгасан ажлыг гүйцэтгэлээ. Тухайлбал, монгол зургийн уламжлалт сургалт, бүтээн туурвих арга ухаан, технологийг судлан шинжилж сургалтын загвар, зөвлөмж, гарын авлага боловсруулах, өвлүүлэн хөгжүүлэх, нийтийн хүртээл болгох, боломж, арга замыг тодорхойлох зорилгоор “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлыг 2019 оны 10 дугаар сарын 14-ны өдөр зохион байгуулж, монголын зураач, урчууд, бурханч нарыг сурган бэлтгэж байсан уламжлал хийгээд монгол зургийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн цагаас өнөө хүртэлх үед хамрагдах монгол зургийн сургалтын бодлого, хөтөлбөр, заах арга барилыг харьцуулан судалж, санал, дүгнэлт дэвшүүлсэн 12 илтгэлийг сонсон хэлэлцэж, эмхтгэлийг хэвлүүлэв. Түүнчлэн уламжлалт болон орчин үеийн монгол зургийн уран сайхны дүр дүрслэл, утга бэлгэдэл, зурж гүйцэтгэх арга ухаан, монгол зургийн хувьсал өөрчлөлт, цаашдын чиг хандлагын асуудлыг хөндсөн “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2020 оны 3 дугаар сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулж илтгэлүүдийн эмхтгэлийг хэвлүүлээд байна.

Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улсад томилолтоор ажиллах удирдамжийн дагуу Катманду хотод орших танка зургийн сургуулиуд, номын сан, музей, хийд, хөдөө орон нутагт орших Нишар Чойпилин хийдэд Балбын уламжлалт гар урлалын болон танка зургийн судалгааны ажил гүйцэтгэв. Үүнд Катмандугийн Дүрслэх урлагийн сургуулийн гар урлалын багш Sujan Chitrakar, Танка зургийн багш Lok Chitrakar, нэрт дархан, бурхан урлаач Jeevan Manarjan, Abhishek Singh нар болон Sara Enterprises, Rincheling танка зургийн сургуулийн багш нар Binod Lama, Tashi Lama, Bimala tamang, Yba Sriya зэрэг уран бүтээлч, багш, судлаачидтай уулзаж ярилцсан тэмдэглэл, цуглуулсан материалаа монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар, зөвлөмж боловсруулахад ашиглав.

“XX зууны монгол зураг” ганц сэдэвт зохиолд монгол зургийн үүсэл хөгжлийн түүхэн тойм, уран сайхны сэтгэлгээ, монгол зургийн төрөл зүйл (аж байдлын зураг, хөрөг зураг, байгаль, мал амьтны зураг, хүрээ хийд, хот суурины сэдэвт зураг), БНМАУ-ын Төр Засгийн газраас дүрслэх урлагийн талаар баримталсан бодлого шийдвэр, монгол зургийн мэргэжлийн сургалт, монгол зургийн нэрт төлөөлөгч Б.Шарав, Цагаан Жамба, Д.Дамдинсүрэн, Ү.Ядамсүрэн, А.Сэнгэцохио, Ц.Даваахүү, 1990-ээд оны монгол зургийн гол төлөөлөгч Г.Пүрэвбат, Д.Бадам, М.Баярмагнай, Д.Уртнасан, Б.Баярт-Од тэргүүтэй зураач урчуудын уран бүтээлийн дүр дүрслэл, утга агуулга, зурж гүйцэтгэх арга ухаан, материал хэрэгсэл хийгээд монгол зургийн цаашдын чиг хандлагын талаар шинэлэг санаа таамаглал дэвшүүлж, үнэлэлт дүгнэлт өгсөн болно.

I. ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ, СУДАЛГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

а. Зорилго. Монголчуудын зураг урлаг, гоо сайхны сэтгэлгээний өвөрмөц онцлогийг илтгэн харуулах соёлын нандин өвийн нэг бол монгол зураг мөн. 1990-ээд оноос Монгол улсад ардчилал, олон ургальч үзэл дэлгэрч, орчин үеийн зураг, урлалын олон янзын чиг хандлага, урсгал чиглэл, хэв маяг нэвтрэхийн хэрээр уламжлалт монгол зургийн дүрслэл, илэрхийллийн арга ухаан, бүтээн туурвих дэг ёс, технологид ихээхэн хувьсал, өөрчлөлт гарч байна. Энэхүү өөрчлөлт монгол зургийн уламжлал, шинэчлэл, хөгжилд эерэг, сөрөг олон үр дагаварыг авч ирж байгаагийн дотор монгол зураг, урлалын хэв маяг, бүтээн туурвих уламжлалт арга ухаан ихээхэн алдагдахад хүргэж байгааг анхаарахгүй байж боломгүй. Ийм учир Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлийн жагсаалтад орсон “Монгол зургийн урлал”-ыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, монгол зургийн уламжлалт арга технологид суралцах, уламжлалт монгол зургийн бүтээлийг судлан шинжилж, нийтийн хүртээл болгох, монгол зургийн арга ухааныг өвлүүлэн хөгжүүлэх, дэлгэрүүлэх боломж, арга замыг тодорхойлоход энэхүү суурь судалгааны зорилго оршиж байна.

б. Шаардлага. БСШУ-ны сайдын 2011 оны 84-р тушаалын хавсралтад “Монгол зургийн урлал”-ыг Монгол улсын соёлын биет бус өвийн төлөөллийн үндэсний бүртгэлд хамруулсан юм. Тиймээс дүрслэх урлаг судлал, соёлын хүн судлал, түүх болон философийн шинжлэх ухааны уулзвар дээр:

Монгол зургийн дүрслэл, илэрхийллийн хувьсал хөгжлийн асуудлыг нягтлан судлах; Монголчуудын сэтгэлгээний онцлог, байгаль ертөнцийг үзэх үзэл, хандлага монгол зурагт хэрхэн илэрч буйг судлах; Монгол зургийн урлан бүтээх онол арга зүйн асуудлыг судлах; Монгол зургийн уламжлалт грунт, шороон будгийн технологийг судлан тодруулах,

в. Үндэслэл. Орчин цагийн техник, технологийн дэвшил, даяаршилын нөлөөнд монгол үндэстэн үндэсний онцлогоо хадгалан оршин тогтнох суурь, язгуур үнэт зүйлсээ улам бүр алдсаар байна. Монгол зураг нь монгол үндэстний язгуур соёлын үнэт өв, урлагийн үндсэн төрөл зүйлийн нэг боловч харьцангуй бага судлагдсан, шинэ тулгар судлагдахуун гэж ойлгож болно. Тиймээс монгол зураг судлалыг өмнө дурдсан шинжлэх ухааны уулзвар дээр судлаж, соёлын энэхүү өвийг

сурвалжлан тодруулах замаар монгол зургийн уламжлалт урлан бүтээх арга ухаан, үндэстний өв соёл, оюун сэтгэлгээний өвөрмөц дахин давтагдашгүй шинж чанарыг нь тодруулах зайлшгүй шаардлага байна.

“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн календарчилсан төлөвлөгөө

“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх санхүүжүүлэх 2018 оны 2 дугаар сарын 10 ны өдрийн Уулс-2018/39 дугаар гэрээний 2 дугаар хэсрэлт

ТӨСЛӨӨР ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН КАЛЕНДАРЧИЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ
/Ажлын программ/

Д.д	Төслийн хүрээнд гүйцэтгэх тодорхой үе шатны ажлын нэр	Эхлэх дуусах хугацаа (Он, сар)	Гүйцэтгэгчдийн овог, нэр, мэргэжил	Тухайн шатныг үр дүн
2018 он				
1	“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн судал-гааны арга зүй, хийж гүйцэтгэх ажлын календар-чилсан төлөвлөгөөг боловс-руулах, ДДУС-ийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэл-цүүлэн батлуулах	2018.04-05 сар	Б.Баяртөр, урлаг судлаач	Суурь судалгааны арга зүй, хийж гүйцэтгэх ажлын календарчилсан төлөвлөгөө батлагдана
2	Төсөлд үндсэн болон гэрээт хэлбэрээр оролцогчдын гүйцэтгэх ажлын нарийв-чилсан төлөвлөгөөг батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах	2018.05 сар	Б.Баяртөр, урлаг судлаач	Төсөлд оролцогчдын ажлын нарийвчилсан төлөвлөгөө, ажил гүйцэтгүүлэх гэрээ бэлэн болно
3	Монгол зургийн судалгаанд холбогдох эх сурвалж, материал цуглуулах (уран бүтээлийн фото, судалгааны ном, товхимол, сонин сэтгүүл, түүний зарим хуулбар)	2018.06-12 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, О.Ням-Очир, уран бүтээлч	Судалгааны эх хэрэглэгдэхүүн, материал цугларна
4	Монгол зургийн сургалтын гарын авлага, сурах бичиг, монгол зураг сургалтын материал, эх хэрэглэгдэхүүн цуглуулах	2018.09-12 сар	Г.Амарсанаа, багш, зураач	Судалгааны эх хэрэглэгдэхүүн, материал цугларна
5	Монгол зургийн уламжлалт болон орчин үеийн арга ухаан, эрдэм мэдлэгийг эзэмшсэн зураач, уран бүтээлчдийг сурвалжлан илрүүлж ярилцлага, сурвалжлага авах	2018.09-12 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, О.Ням-Очир, уран бүтээлч	Судалгааны эх хэрэглэгдэхүүн, материал цугларна
6	Явцын тайлан хүргүүлэх	2018.12 сар	Б.Баяртөр, урлаг судлаач	Явцын тайлан бичиж хүргүүлнэ.
2019 он				
1	Судалгааны эх хэрэглэг-дэхүүн, цуглуулсан мате-риалаа боловсруулах. /бүртгэн гэмдэглэх, бүлэглэх, системч-лэх, бичиж, боловсруулах, компьютерт шивэх, скайнер, каноноор хувилах, гэх мэт/, анхны санаа таамаглал дэвшүүлж, явцын үр дүнг хэлэлцүүлэх	2019.01-10 сар	Б.Баяртөр, урлаг судлаач С.Бадрал, багш, урлаг судлаач, О.Ням-Очир, уран бүтээлч	Судалгааны эх хэрэглэгдэхүүнийг боловсруулж, анхны санаа таамаглал дэвшүүлнэ. Судалгааны явцын үр дүнг хэлэлцсэн байна.
2	Монгол зургийн сургалтанд холбогдох материал, эх хэрэглэгдэхүүнийг боловс-руулах, явцын үр дүнг хэлэлцүүлэх	2019.03-12 сар	Г.Амарсанаа, багш, зураач	Судалгааны эх хэрэглэгдэхүүнийг боловсруулж, явцын үр дүнг хэлэлцсэн байна.
3	“Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах	2019.03 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, илтгэгчид	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж, хурлын илтгэлийн эмхтгэл хэвлэгдсэн байна
4	Монгол зураг судлалын зарим илтгэл, өгүүлэлийг англи, орос,	2019.09-12 сар	Д.Уранчимэг, урлаг судлаач	Гадаад хэлээрх судалгааны зарим материал



	хятад хэлнээс монгол хэлрүү орчуулах			орчуулагдсан байна
5	Монгол зургийн уламжлалт арга, технологи судлах зорилгоор Түвд, Балба улсад ажиллах	2019.09-12 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, Д.Уранчимэг, урлаг судлаач	Монгол зургийн уламжлалт арга технологид холбогдох материал эх хэрэглэгдэхүүн цугларна
6	Явцын тайлан хүргүүлэх	2019.06 ба 12 саруудад	Б.Баяртөр, урлаг судлаач	Явцын тайлан бичиж хүргүүлнэ
2020 он				
1	“ХХ зууны монгол зураг” нэг сэдэвт судалгааны бүтээл бичих	2020.01-08 сар	Б.Баяртөр, урлаг судлаач	Судалгааны үр дүнгээр “ХХ зууны монгол зураг” нэг сэдэвт бүтээл бичсэн байна
2	Монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар зөвлөмж бэлтгэх	2020.01-11 сар	Г.Амарсанаа, багш, зураач	Монгол зургийн сургалтын загвар зөвлөмж бэлэн болсон байна
3	“Монгол зургийн хувьсал, өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулна	2020.03 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, илтгэгчид	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулагдаж, хурлын илтгэлийн эмхтгэл хэвлэгдсэн байна.,
4	Явцын тайлан хүргүүлэх	2020.06 сар	Б.Баяртөр, урлаг судлаач	Явцын тайлан бичиж хүргүүлнэ
5	ДДУС-ийн Эрдмийн зөв-лөлийн хурлаар “Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн үр дүнг хэлэлцүүлнэ	2020.10 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, төсөлд оролцогчид	Төслийн үр дүнг хэлэлцэж шийдвэр гаргасан байна.
6	“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн үр дүнд экспертиз хийлгэнэ	2020.11 сар	Б.Баяртөр, урлаг судлаач	Төслийн үр дүнд хөндлөнгийн шинжээчдийн дүгнэлт гаргуулсан байна
7	Эрдэмтэн судлаачид, хөнд-лөнгийн шинжээчдийн санал, зөвлөмжийг судалгааны бүтээлдээ тусгаж, төслийн үр дүнг эцсийн хувилбараар засаж боловсруулах	2020.11 сар	Б.Баяртөр, урлаг судлаач, О.Ням-Очир, уран бүтээлч, төсөлд оролцогчид	Төслийн үр дүнд санал зөвлөмжийг тусгаж, эцсийн хувилбараар засаж боловсруулсан байна
8	“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн үр дүнг захиалагч, санхүүжүүлэгч талд хүлээлгэн өгнө	2020.12 сард багтаана	Б.Баяртөр, урлаг судлаач, төсөлд оролцогчид	Төслийн үр дүнг захиалагч, санхүүжүүлэгч талд хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна

Захиалагчийг төлөөлж:

 Д.Одгэрэл
 БСШУСЯ-ны ШУТБГ-ын дарга
 УХА0148
 1116126429 9116621

Санхүүжүүлэгчийг төлөөлж:

 Д.Энхжаргал
 ШУТСангийн Захирал
 ТТ700 4126613

Гүйцэтгэгчийг төлөөлж:

 Д.Уранчимэг
 СУИС-ийн ДДУС-ийн захирал
 Төслийн удирдагч:


II. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Нэг. Шинжлэх ухааны судалгааны арга

Нийгэм, сэтгэлгээний болон урлаг судлалын ерөнхий онол арга зүйг судалгаа шинжилгээний тулгуур суурь үндэс болгохын зэрэгцээ тухайн судлагдахуун, судалгааны объект бүрт анализ, синтез, индукци, дедукци, түүхэн зүй, логик зүйн арга, харьцуулалт, интерпритацын аргыг ашиглан ХХ зууны монгол зургийн хувьсал өөрчлөлтийг торуулна.,

Дүрслэх урлаг, түүх, бэлгэдэл зүй, философийн болон шинжлэх ухааны салбар дундын асуудлыг хамруулна.,

Монгол зургийн язгуур хэв шинж, түүний хувьсал өөрчлөлтийг бүтэц тогтолцооны арга буюу систем (түүх, нийгэм, улс төр)-ийн аргаар авч үзнэ.,

Гадаад, дотоодын эрдэмтэн, судлаачдын судалгааны үр дүн, санаа таамаглалыг судалгааны үр дүнтэй жишин харьцуулж дүр дүрслэл, утга агуулгын онцлогийг тодруулна.,

Монгол зургийн мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо, түүнд холбогдох үзэгдэл юмсын учир шалтгааныг тайлбарлахад чиглэгдсэн онолын судалгаа, тайлбарыг эрхэмлэнэ.

Хоёр. Судалгааны бүтээлийн бичвэрт тавигдах журам, шаардлага (аппаратур хэрэгсэл бүрдүүлэлт):

Ерөнхий зүйл: Судалгааны үр дүнг компьютерийн Microsoft Word, Sibeluis 6-7 программаар, А4 хэмжээний цаасан дээр, “Times New Roman” шрифтээр, мөр хоорондын зайг 1,5 см, 12 үсгийн хэмжээтэй бичиж бэлтгэнэ.

Холбогдох зураг, схем, хүснэгт, товчилсон үгийн жагсаалт, нэр томъёоны тайлбар зэргийг журмын дагуу гүйцэтгэж хавсаргана.

Судалгаанд холбогдох бичгийн болон биет эх сурвалжуудын жагсаалт, түүхэн дурсгал, биет үзмэрүүдийн мэдээллийг хадгалж буй цуглуулагч, хувь хүн, музей, галерей, номын сан, түүхэн дурсгалт газрын нэрийн жагсаалт, судалгаатай холбоотой нэрийн хэлхээс, он цагийн хэлхээсийг журмын дагуу гүйцэтгэж хавсаргана.

Цаг хугацаа, он тооллыг тэмдэглэх. Төслийн судлагдахуунуудтай холбоо, хамаарал бүхий цаг хугацааг сайтар нягталж, үнэн зөв тэмдэглэнэ. Түүхэн баримт эх сурвалжуудын холбогдох цаг хугацааг он сараар буюу он жилээр тодорхойлж

болно. Мөн зуун жилээр (зуунаар) тодорхойлж болно. Жишээ нь: АТӨ I зуун гэх мэт. Зарим судлагдахуунтай холбоотой цаг хугацааг тодорхойлохдоо он цагийн хязгаарлалыг тавина. Ингэхдээ хоёр тооны хооронд зураас тавина. Хэрэв хоёр он нэг зууны дотор багтаж байгаа бол сүүлийн тоог зөвхөн хоёр оронтой тоогоор тэмдэглэнэ. Бичвэрт цаг хугацааг араб тоогоор тэмдэглэнэ. Жишээ нь: он, сар, өдрийг 1965.10.23 гэж тэмдэглэж болно. Харин өдрийг заагаагүй бол 2018 оны 07-р сар гэж тэмдэглэнэ. Сарыг 01-р, 02-р, 03-р, 12-р сар, өдрийг 01, 02, 03, 10, 11 гэж бичнэ.

Дан хаалт (.....)-ыг урьдах үг болон санааг тайлбарласан, хэрэв тэр тайлбарыг мэддэг бол уншихгүй өнгөрч болох, үүнээс болж өгүүлбэрийн аль нэгэн гишүүн илүүдэх юмуу дутагдахгүй байхаар найруулдаг. Харин хашилт “.....”-ыг эх сурвалжаас тэр хэвээр нь эшлэл болгон хуулж оруулсан үг өгүүлбэр, эсвэл ямар нэгэн зүйлийн оноосон нэрийг тэмдэглэхэд хэрэглэнэ.

Эшлэл гэдэг нь ямар нэг эх сурвалжаас тэр чигээр нь таслан авч хашилтанд бичсэн зүйлийг хэлдэг. Харин тэр эшлэл чухам хаана байгааг заасан бичвэрийг зүүлт гэнэ. Зүүлт тэмдэглэх олон арга, хэлбэр байна. Эдгээрээс тус судалгааны бичвэрт хашилтанд авсан хэсгийнхээ эцэст хаасан хашилтны баруун дээд талд жижиг тоогоор дугаар тавьж, хуудасны сүүлчийн мөрийн дор тусгай зураасаар тусгаарлан мөнөөх дугаараа бичиж, жижиг үсгээр зүүлтийг бичих хэлбэрийг баримтлана.

Ж.нь. “...монгол хүний дүрийг урлагт бүтээх гэсэн нам төрийн бодлого”³

³ Б.Баяртөр. Монгол уран зураг. УБ., 2001.9-р тал.

.....Нэг сурвалжийн нэр дараалан гарч байгаа тохиолдолд “Дурдсан зохиол” гэж бичээд зөвхөн хуудасны дугаарыг бичнэ. “Мөн тэнд” гэж бичээд хуудсыг зааж болно.

Ж.нь. “...бэлгэдлийн нэгэн тулгуур ай болж явдаг”⁴

⁴ Дурдсан зохиол.18 эсвэл Мөн тэнд.18

Тус судалгааны бичвэрт ашигласан хэрэглэгдэхүүнийг хавсаргана. Тэдгээрийг бичих стандарт, журмыг сахиж мөрдөнө. Ашигласан хэрэглэгдэхүүний жагсаалтанд орох зарим бүтээл бие дааж хэвлэгдээгүй өөр нэртэй номын хэсэг

болж орох нь бий. Түүнийг дараахь байдлаар тэмдэглэнэ. Баяртөр Б. “Зураач Д.Дамдинсүрэнгийн уран бүтээлийн онцлог”. Бурхач, уран зураач Д.Дамдинсүрэнгийн амьдрал, туурвил, судлал. УБ., 2012. 193-198-р тал

Гурав. “ХХ зууны монгол зураг” ганц сэдэвт бүтээлийн агуулга:

ОРШИЛ:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛ ЗУРГИЙН ҮҮСЭЛ, УРАН САЙХНЫ ХЭВ МАЯГ

- 1.1. Монгол зургийн үүсэл хөгжлийн тойм
- 1.2. Уран сайхны сэтгэлгээ, дүрслэлийн онцлог

ХОЁРДУГААР БҮЛЭГ: УЛАМЖЛАЛТ МОНГОЛ ЗУРГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛ

(Богд хаант Монгол Улсын үе)

- 2.1. Аж байдлын зураг
- 2.2. Хөрөг зураг
- 2.3. Байгаль, мал, амьтны зураг
- 2.4. Хүрээ хийд, хот суурины сэдэвт зураг

ГУРАВДУГААР БҮЛЭГ: СОЦИАЛИСТ РЕАЛИЗМ МОНГОЛ ЗУРАГТ

(БНМАУ-ын үе)

- 3.1. БНМАУ-ын Төр засгийн бодлого, шийдвэр
- 3.2. Монгол зургийн мэргэжлийн сургалт
- 3.3. Гол бүтээл туурвилууд

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: МОНГОЛ ЗУРГИЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА (Монгол Улсын үе)

- 4.1. Нийгмийн шилжилт ба 1990-ээд оны монгол зураг
- 4.2. Монгол зураг дахь шинэчлэл

ТӨГСГӨЛ:

АШИГЛАСАН МАТЕРИАЛ:

ХАВСРАЛТ ЗУРАГ:

III. СУДАЛГААНЫ ОБЪЕКТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Богд хаант Монгол улсын үеийн болон монголын социалист реализмын үеийн, 1990-ээд оны үеийн монгол зургийн бүтээлүүдийг харьцуулан судалж, уран сайхны дүрслэл, илэрхийллийн хувьсал өөрчлөлтийг тодруулна.

ХХ зууны эхэн үеийн монгол зургийн судалгаанд хөзөр, үйчүүр зэрэг цаасан тоглоомын зураг, ном судрын зураг чимэглэл, сүм хийдийн ханын зураг (хангагч эрдэнэ), “Наймдугаар Богд” (хэд хэдэн хувилбар бий), “Эх дагина Дондогдулам”,

“Балдан Гачин”, “Цорж Лувсандондов”, Сономцэрэнгийн “Түшээт хан Насантогтох”, “Насантогтохын эхнэр Ичинхорлоо” зэрэг хөрөг зураг, “Богд хааны зуны ордон”, “Богд хааны өвлийн ордон”, “Лхас”, Балганы зурсан “Их хүрээ”, Жүгдэрийн “Их хүрээ” зэрэг хүрээ хийд, хот суурин газрын сэдэвт зураг, Лодой, Цагаан Жамба, Б.Шарав нарын туурвисан аж байдлын болон байгаль, мал амьтны сэдэвт зураг бүтээлийг хамруулна.

Социализмын үед монголын соёл урлагт нэвтрэн хөгжсөн “социалист реализм” уламжлалт монгол зурагт хэрхэн нөлөөлснийг Ү.Ядамсүрэн, Д.Дамдинсүрэн, А.Сэнгэцохио, Ц.Даваахүү нарын бүтээл туурвилд тулгуурлан тодруулна.

1990 оноос монголын улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын бүхий л салбарт өөрчлөлт, шинэчлэл, ардчилалын давалгаа түрэн ирж, монголын уламжлалт урлаг, уран сайхны соёлд чөлөөт сэтгэлгээ, дүрслэн илэрхийлэх олон хэв маяг, арга ухаан, техник дэлгэрэхэд хүргэжээ. Энэ нь монгол зургийн бас нэгэн өвөрмөц хэв маяг дэлгэрэн хөгжихөд нөлөөлж байгааг 1990-ээд оны үеийн монгол зургийн төлөөлөгч Г.Пүрэвбат, Д.Бадам, М.Баярмагнай, Д.Уртнасан, Б.Баярт-Од нарын бүтээлд үндэслэн тодруулна.

Монгол зургийн уламжлалт болон мэргэжлийн сургалт, урлан бүтээх арга ухаан, технологи, сурах бичиг, гарын авлагад холбогдох материалыг хамруулан судлана.

IV. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

IV.1. “ХХ ЗУУНЫ МОНГОЛ ЗУРАГ” ГАНЦ СЭДЭВТ БҮТЭЭЛ

“ХХ зууны монгол зураг” судалгааны бүтээлийн нэгдүгээр бүлэгт монголын үндэсний язгуур зураг дүрслэлийн үүсэл хөгжил, төрөл зүйл, уран сайхны сэтгэлгээний хэв маяг, монгол хүний байгаль, нийгмийн тухай үзэл төсөөллийг анхааран авч үзлээ. Монгол зургийн үүсэл хөгжил, уран сайхны сургууль бүрэлдэн төлөшсөн түүхийг судлан үзэхэд тэрээр эртний соёл иргэншилт Хүннү, Уйгар, Түрэг, Кидан улсын зураг урлалаас эх авч хөгжсөөр, Ил хаадын үед араб, перс хэлт ард түмний соёл урлагт нөлөөлж, улмаар Перс-Монгол миниатюр хэмээх номын чимэг зургийн төрөл хэлбэрийг ч үүсгэж байжээ. Түүнчлэн Энэтхэг, Түвдээс үүсэлтэй бурханы шашны зураг урлаг, монголын уламжлалт хөзөр, үйчүүрийн зураг, ном судрын чимэг зэрэг нь монгол зургийн гол үндэс суурь болсон байна. Ийм хэлбэрийн

зураг дүрслэл дараа үедээ өвлөгдөж, монголын урлаг, соёл, зан үйл, шашин шүтлэгт нэвтэрч, ардын урлагийн шимт хөрс болохын зэрэгцээ бодит юмс үзэгдлийг ургуулан сэтгэж дүрслэх, хийсвэрлэх, ёгтлох, егөөдөх, бэлгэдэх, адилтгах, зүйрлэх, хэтрүүлэх зэрэг уран сайхны сэтгэлгээний хэв маягийн цаашдын хөгжилд нөлөөлжээ. Энэхүү хураангуйлан онож, хийсвэрлэн илэрхийлэх сэтгэлгээ нь юмс үзэгдлийн гол шинжийг тодруулан дотоод мөн чанарыг танин барихад чиглэгдсэн бөгөөд нүүдэлчдийн уран сайхны сэтгэлгээний хэв маяг, өвөрмөц онцлогийг гүнзгий тод тусгаж, улмаар олон зууныг дамжин монголын ард түмний урын санд уламжлагдан хөгжсөн байна.

Хоёрдугаар бүлэгт XIX зууны сүүлч, XX зууны эхэн буюу Богд хаант Монгол улсын үед бүтээгдсэн монгол зургийн гол дурсгалууд, Хүрээ хийд, хот суурины зураг, Цагаан Жамба, Б.Шарав нарын бүтээлд тулгуурлан уламжлалт монгол зураг дахь байгаль, хүн, мал, амьтны дүр дүрслэлийн хэв маяг, адилтгал, зүйрлэл, ёгтлолын сэтгэлгээ, өнгө зохиомж, дүрс, зураасны онцлог тэргүүтэнг судлан тодруулав.

XX зууны эхээр монголчуудын үндэсний ухамсар сэргэж эрх чөлөө, тусгаар тогтнол, шударга ёсны төлөө тэмцэл өрнөсөн нь зураг урлагийн утга агуулга, урлахуй ухааны арга барил, уран сэтгэмж, дүрслэлд дорвитой нөлөөлсөн байна. Энэ үеийн бүтээлд монголчуудын ахуй амьдралын явдал учрал, ард түмний ядуу зүдүү байдал, ихэс дээдэс, хаад ноёд, хатад түшмэдийн ихэмсэг дээрэнгүй зан араншинг уран хошин хэв шинжит дүрээр илэрхийлсэн байдаг. Ийм зураг урлагаас тухайн үеийн монгол орны нийгэм, хүмүүсийн амьдралын тод томруун зураглал харагдаж байдаг. Ялангуяа ардын урлагийн баялаг өвөрмөц уламжлал, дүрслэл илэрхийллийн өв сангаас эх авч хөгжсөн аж байдлын монгол зургийн урнаар сэтгэх, найруулах, бэлгэдэх, зүйрлэх арга нь уран сайхны чөлөөт илэрхийлэл, шууд зохион туурвих боломж хөгжин гарах бүх бололцоог хангасан учир ардчилсан бүтээлч онол, сэтгэлгээний илрэл хэмээн үзэж болно.

Эрт үеийн нүүдэлчдийн зураг урлалд ертөнцийн юмс үзэгдлийн тухай нарийн битүүлэгдмэл үзэл ойлголт, гүн санаа туссан байдаг нь монголын эрдэмтэн мэргэд, зураач, урчууд бодот юмсыг танин мэдэхийн тулд хийсвэр сэтгэхүйн ёс үндсийг баримтлан нэгийг нөгөөтэй нь харьцуулан, шүүн тунгаах замаар дүрслэн илэрхийлдэг сэтгэлгээтэй холбоотой. Монголын уламжлалт зураг дүрслэл бурханы урлаг ноёлон хөгжиж байсан XVIII, XIX зууны үед ч буддын шашны урлахуйн ухааны

онол дүрэмд авталгүй чөлөөтэй хөгжиж, байгаль, нийгмийн үзэгдэл, үйл явдлын утга учир, мөн чанарыг хүүрнэн өгүүлэх байдлаар тайлбарлан илэрхийлсээр байжээ. Зураг дүрслэлийн ийм хэлбэр, хэв маяг нийлбэрлэн хөгжсөөр монголчуудын уламжлалт зан үйл, шүтлэг бишрэл, эрхэлдэг аж ахуй, төр, шашны ёслол, хүрээ, хийдийн байдал, цам, майдар, даншиг наадам зэрэг нийгмийн томоохон үйл явдлыг харуулсан уран зураг болон төлөвшсөн байна.

Түүнчлэн XIX-XX зууны эхэн үед хот, хүрээ, сүм хийдийн байдлыг ойр орчмын газар нутгийн хамт бүтнээр нь зурах, дүрслэх хандлага түгэн дэлгэрсэн нь хавтгайд орон зай, эзлэхүүнийг дүрслэн илэрхийлэх өвөрмөц арга, онцлог шинжийг судлан тодруулах нэгэн эх сурвалж болж байна.

XX зууны эхэн үе болоход монгол орон дахь хүрээ хийдийн суурин газрын тоо 700 гаруйд (сүүлийн үеийн судалгаагаар 1000 орчим) хүрсэн тухай мэдээ бий. Тэр бүгд улс орны хөгжил, хүн ардын амьдрал, нийгэмд тодорхой хэмжээгээр нөлөөлж, улмаар хүрээ, хийд, хот суурины сэдэвт зураг бие даан хөгжих нэг үндэс болжээ. Ялангуяа ийм сэдэвт зурагт тухайн үеийн монгол нутагт бодитойгоор оршин байсан хүрээ, хийдийн байдал төдийгүй монгол гэр, өргөө, гэр хэлбэрт сүм, дугана, дацан, уран барилга, монгол үндэсний архитектурын хувьсал хөгжлийн түүх тод томруун туссан байдаг.

Гуравдугаар бүлэгт БНМАУ-ын төр, засгийн газрын зүгээс дүрслэх урлагийн талаар баримталсан бодлого, монгол зургийн мэргэжлийн сургалт, түүний үр дүнд үүсэн дэлгэрсэн “монгол зураг”-ийн шинэ хэв маяг, сэдэв, агуулгыг Д.Дамдинсүрэн, Ү.Ядамсүрэн, А.Сэнгэцохио нарын бүтээлд үндэслэн тодорхойлов.

XX зууны монголын нийгэм, соёл, гоо сайхны сэтгэлгээ, үнэлэмж нь нэг нэгээсээ ялгарч танигдахуйц дүрслэл, илэрхийлэл бүхий монгол зураг үүсэн хөгжихөд нөлөөлжээ.

Тухайлбал социалист нийгмийн үеийн монголын дүрслэх урлаг нь МАХН-ын бодлого, Зөвлөлтийн дүрслэх урлагийн нөлөөгөөр социалист реализмын аргыг эзэмших замаар, ангич, намч зарчим дээр хөгжиж байжээ. Төр Засгийн энэхүү бодлого, шийдвэрийн үр дүнд монгол зургийн уламжлалт сэдэв, агуулга төдийгүй уран сайхны арга, дүрслэл, илэрхийллийн хэл, хэллэг, ур гүйцэтгэл, технологи, бийр, будаг, грунт зэрэг материал хэрэгсэл ч хувьсан өөрчлөгдөж, улмаар монгол зургийн шинэ хэв маяг дэлгэрэн хөгжсөн байна.

Монгол зургийн дүрслэн илэрхийлэх арга ухаан, уран сайхны сэтгэлгээнд нэлээд өөрчлөлт, шинэчлэл нэвтэрсэн нь 1960, 70, 80-аад оны монгол зургийн бүтээлүүдээс ил тодхон ажиглагдаж байна. 1950, 60-аад оны үе бол Орос, Европын тосон будгийн уран зургийн арга ухаанд суралцсан монголын анхны дээд мэргэжлийн зураачид бүтээлээ туурвиж, улмаар уламжлалт монгол зурагт тосон будгийн зургийн аргыг нэвтрүүлэх, тосон будгаар монгол зургийн аргаар бүтээн туурвих шинэ хандлага илэрч эхэлсэн үе юм. Энэ нь уламжлалт монгол зургийн зохиомж, дүр дүрслэлийн арга ухааныг сонгодог урлагийн ололтоор баяжуулж, хувьсгалч, эх оронч үзэл, социалист реализмын зарчмыг уран сайхны үндэслэл болгон дэвшүүлэх нам, төр засгийн бодлогын үр дүн байв. Ийнхүү энэ цаг үеийн монгол зургийн бүтээлүүд нь социалист нийгмийн өрнүүн дэлгэр бүтээн байгуулалт, ард түмний оюун санаа, ахуй амьдралын өөрчлөлт, нам, төр, засгийн удирдагчид, ажилчин хөдөлмөрчин хүний хэв шинжит дүрийг тод томруун дүрслэх зорилготой уялдан шинэ агуулга, хэлбэрээр баяжиж, өвөрмөц нэгэн хэв маяг бүхий өв дурсгал, уран сайхны соёлыг бий болгосон байна.

Дөрөвдүгээр бүлэгт XX зууны сүүлч буюу 1990-ээд оны үеийн монгол зургийн сэдэв, агуулга, төрөл зүйл, уран сайхны дүрслэл, илэрхийлэлийн онцлог юу байв, түүнд чухам ямар хүчин зүйл хэрхэн нөлөөлсөн болохыг холбогдох зураач, урчуудын гол бүтээл туурвил, эрдэмтэд, судлаачдын зохиолд тулгуурлан тодруулж, монгол зургийн хөгжлийн чиг хандлагын талаар үнэлэлт дүгнэлт өгч, санал дэвшүүлэв.

1990-ээд оны үе бол монголчуудын хувьд нийгэм, эдийн засаг, улс төрийн нэг тогтолцооноос нөгөөд шилжих үйл явц ид өрнөсөн, түүхэн, өвөрмөц цаг байв. Нийгмийн энэхүү өөрчлөлт, шинэчлэл, ардчилсан хувьсгалын давалгаа нь уламжлалт соёл урлагийг ч тойроогүй билээ. Ялангуяа урлаг, уран сайхны соёлд чөлөөт сэтгэлгээ, дүрслэн илэрхийлэх олон хэв маяг, арга ухаан, техник дэлгэрсэн юм. Өөрөөр хэлбэл 1990-ээд оноос монголд өрнө, дорнын улс үндэстнүүдийн соёл урлагийн шинэ содон төрөл зүйл, хэв маяг, арга техник чөлөөтэй нэвтэрч, улмаар үндэсний соёл, гоо сайхны сэтгэлгээ, урлан бүтээх уламжлалт арга ухаанд нөлөөлж эхэлсэн байна.

Монголын соёл урлагийг ардчилсан нийгэм, зах зээлийн харилцаанд нийцүүлэн хөгжүүлэхэд Монгол Улсын Их Хурал, Засгийн Газар онцгой анхаарч холбогдох хууль, дүрэм журмыг боловсруулан хэрэгжүүлжээ. Эдгээр нь хараат

бусаар чөлөөтэй сэтгэж бүтээн туурвих, авъяас чадвар, уран бүтээлээ бодитоор үнэлүүлэх, хамгаалуулах, дэлхийн хүн төрөлхтний эрт эдүгээ цагийн соёл иргэншлээс суралцах, үндэсний урлагаа уламжлан хөгжүүлэх, уран сайхны арга, урсгал чиглэлийг эзэмших боломж нөхцөлийг бүрдүүлсэн байна. Энэ бүхэн монгол зурагт чөлөөт сэтгэлгээ, дүрслэн илэрхийлэх олон хэв маяг, арга ухаан, техник дэлгэрч, сэдэв, агуулга нь ч өргөжин тэлэх үндэс суурь болжээ. Түүнчлэн өрнө дахины модернист, контемпорари урлагийн элемент, арга техник 1990-ээд оноос эхлэн монгол зурагт шинээр нэвтэрч, холимог, нийлмэл, зарчмыг баримтлагч зураач, урчууд олширов. Энэ нь цаасан хайчилбар, цоолбор мэт хавтгай дүр дүрстэй эсвэл хэт хурц тод өнгө зохиол, хээлж угалзалсан хэллэг бүхий чимэглэлийн аястай, этгээд гаж хэлбэр маягтай хүн, мал, амьтан, эд юмс дүрсэлсэн монгол зураг нэртэй зүйл дэлгэрхэд ч нөлөөлжээ.

Социализмын үед монгол зургийн гол сэдэв нь хувьсгал, түүхэн үйл явдал, түүхт хүн, нам, төрийн удирдагчид, ажилчин, малчин хүний дүр байдал, байгаль, мал, амьтан байсан бол өдгөө домог үлгэр, ан гөрөө, уламжлалт зан заншил, түүхт дайн тулаан хийгээд өнөөгийн нийгмийн байдал, хотжилт, даяаршил зэргээр өргөжин тэлсэн нь ажиглагдана. Өөрөөр хэлбэл суртал ухуулгын шинжтэй, зориуд магтан дуулсан сүрлэг, өрнүүн сэдэв, агуулгын оронд өнөөгийн нийгмийн амьдралын үнэн дүр төрх, эгэл жирийн хүний үзэл бодол, хүсэл мөрөөдөл, жаргал зовлонг харуулсан өгүүлэмж голлох болжээ.

Суурь уран зургийн болон модернист, контемпорэри урлагийн уран сайхны илэрхийллийн арга хэрэгслийг монгол зургийн урлагт шууд механикаар нэвтрүүлэх нь хөгжил ч, шинэчлэл ч биш юм. Иймэрхүү байдал цаашид удаан үргэлжилбэл монгол зургийн өнгө, зураасны хэмнэл, дүрслэл, илэрхийллийн өвөрмөц хэллэг алдагдан урлагийн түүхэнд “эkleктизм” гэж нэрлэгддэг завсар хоорондын саармаг хандлагаруу орж уусан алга болох аюултай.

Тиймээс Дорно дахины сонгодог урлаг, ардын уран бүтээл, монгол ахуй амьдрал, зан үйл, монгол зургийн өв уламжлалыг ултай нарийн судлах, ахмад зураачдын бүтээлч туршлагаас суралцах явдал чухал байна. Түүнчлэн монгол зургийн үнэлэмж, үнэлгээг өсгөн нэмэгдүүлэх, сурталчилах, шүүмж судлалыг эрс хөгжүүлэх зэрэг өнөөдөр тулгамдаж байгаа олон асуудлыг хэр зэрэг богино хугацаанд, хэрхэн амжилттай шийдэж чадах эсэхээс монгол зургийн хөгжлийн өнөө ирээдүй шууд шалтгаална.

IV.2. “МОНГОЛ ЗУРГИЙН СУРГАЛТЫН ЗАГВАР ЗӨВЛӨМЖ”

(монгол зургийн сургалтын уламжлал, шинэчлэлийн зарим асуудалд)

Төв Азийн нүүдлийн соёл, нүүдэлчдийн харилцааны гол онцлог хүн-байгаль гэсэн гоо сайхны үзэл, харилцаа хамааралд орших байгалиас эхтэй. Энэ утгаараа суурьшмал соёл иргэншилтэй ард түмний сэтгэлгээнээс ихээхэн ялгаатай.

Нүүдэлчдийн уламжлалын хувьд байгаль эхийг шүтэх, юмс үзэгдлийг уран сайхны үүднээс тайлбарлах сэтгэхүйд суурилсан байдаг тул байгалиас эхтэй зураг дүрслэл илүү хөгжсөнийг нэн эртний зураачдын уран сайхны илэрхийллийн үр дүн болох хадны зургуудаас харж болно. Тэдгээр дурсгалуудад эртний хүний оюун сэтгэхүйн уламжлалыг хадгалсан дүрслэлийн хэллэг язгуур байдлаар үлдсэн тул монголчуудын суурь соёл, уламжлалын зүй тогтлыг ухаж ойлгох эх сурвалж болдог. Домгийн сэтгэлгээний харилцаанаас үүдсэн уран сайхны сэтгэлгээний хэв маяг, язгуур шинж чанар эртнээс ийнхүү төлөвшин ирэхдээ нүүдлийн соёлын хүрээнд дорно дахины арга билгийн тогтолцоо бүхий буддын сонгодог гүн ухааны танин мэдэхүй, гоо сайхны сэтгэлгээний харилцаа хамааралд суурилдаг. Энэхүү язгуур шинж чанар монгол үндэстний соёл, шашин шүтлэг, ёс заншил төлөвшин хөгжихөд түлхэц үзүүлэхийн зэрэгцээ буддын философи, урлахуй ухааны үзэл санаанд хожим зохих хэмжээгээр нөлөөлсөн билээ.

Даяаршлын нөлөөгөөр улс үндэстний соёлын харилцаа өргөжиж буй өнөө үед үндэстэн угсаатан, өрнө, дорнын сэтгэлгээний онцлог, урлаг соёлын харилцан шүтэлцээ нөлөөллийг зөв тодорхойлж үнэлж дүгнэх явдал чухал. Зарим улс үндэстний уламжлал соёл зөвхөн ардын (folklor) хэмжээнд үлдэж буй байдал үндэстний соёлын дархлааг нэмэгдүүлэх, өв соёл уруугаа эргэж харах ёстойг бидэнд сануулж байна. Үндэстэн угсаатны сэтгэлгээ соёлын дархлаа тогтооход олон хүчин зүйлийн нөлөөлөл байх нь гарцаагүй бөгөөд тэдгээрийн нэгэн салаа хүчин зүйл бол үндэстний урлахуй ухаан, монгол зургийн дэг сургууль ба сэтгэлгээний онцлог юм.

Нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлээс улбаатай гоо сайхны сэтгэлгээний хөгжлийн ерөнхий нийтлэг зүй тогтлыг судлах явдал уламжлалт “монгол зураг”-ийн дүрслэлийн онцлог, уран сайхны аргыг тодруулах онолын үндэслэл болох юм.

Нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзэл, байгалийн тухай ойлголт монгол зургийн уран сайхны сэтгэлгээний гол шинж мөн бөгөөд олон мянган жилийн туршид нүүдэлчдийн оюуны ертөнц ямар нэг шашны хүчтэй нөлөөнөөс харьцангуй ангид оршиж байсан онцлогтой. Буддын шашин хожим дэлгэрсэн боловч оюун санааны

чөлөөт байдлаа урт удаан хугацааны туршид хадгалсаар ирсэн явдал нь байгаль, цаг уурын өвөрмөц байдал, түүгээр нөхцөлдсөн эрхлэх аж ахуй, амьдрах арга ухаан, сэтгэх хэв маягтай холбоотой. Энэхүү оюун санааны чөлөөт байдал нүүдэлчдийн соёл иргэншлийг ихэд хүмүүнлэг, энэрэнгүй болгох тул байгалийг хайрлан хамгаалах, зүй зохистойгоор эзэмших зэрэг аж төрөх ёсны хэв маягаас үүдэлтэй ёс суртахууны үнэт чанаруудыг монгол хүний ахуй амьдралд шингээж өгчээ.

Грекийн сэтгэгч Демокрит байгаль, цаг уур, бүс нутгийн онцлогоос улс орны соёл, ёс заншил, сэтгэлгээний шинж байдал хамааралтай гэсэн баримтлалыг дэвшүүлсэн бол Германы гүн ухаантай Г.В.Ф.Гегель энэ тухай бичихдээ “ард олны ертөнцийн санааны байгальтай холбогдох холбоо юм юмны гадаад тал мэт санагдана. Байгаль нь ертөнцийн санааны хөгжих хөрс гэж үздэг болохоор түүнийг хөгжлийн суурь дэвсгэр хэмээвэл зохино”¹ гэжээ. Эндээс үзэхэд нүүдэлчдийн уран сайхны сэтгэлгээ төлөвших үйл явц, шашин шүтлэг, ёс заншил, гоо зүйн сэтгэлгээний онцлог зэргээс хамаарч, үйл ажиллагаагаар уламжлагдаж ирэхдээ монголчуудын ертөнцийг үзэх үзэл, байгаль нийгмийн тухай ойлголт дээр суурилж, монгол үндэстний урлахуй ухааны уран сайхны сэтгэлгээний үндэс гол шинж болжээ.

Уран сайхны сэтгэлгээ нь аливаа бүтээлийг танин мэдэх үндэс суурь тул аливаа уран сайхны бүтээлийн үндэс суурь юм. Энэ нь аливаа уран сайхны бүтээлийн эцсийн үр дүнг танин мэдэх, ойлгож ухамсарлах үндэс суурь гэсэн үг юм. Аливаа уран бүтээлчийн бүтээгч үйл ажиллагаа нь түүний ертөнцийг үзэх үзэл нийгмийн хоорондын харилцааны хүрээг хамарсан үзэл баримтлалаас хамаардаг.

Танин мэдэхүйн нэг өвөрмөц хэлбэр болох уран сайхны сэтгэлгээ нь ухамсрын бус зөн, билгийн мөн чанартай байдаг. Ерөөс энэ сэтгэхүй балчир хүүхдийн ухамсар дээр тод илрээд яваандаа танин мэдэхүйн хөгжилтэй холбоотойгоор арилдаг байна. Гурван нас хүртэл хүүхэд ойлголт, ухамсар мэдрэхүйн үйл ажиллагаагаар тодорхойлогдож зөвхөн өөрийн төсөөллийн талбарт байгаа зүйлд анхааралтай хандаж төсөөллөөр сэтгэдэг. Энэхүү танин мэдэхүйн үйл явц ерөнхий төсөөллийн сэтгэлгээ тухайн объектын нарийн хэсгийн ойлголтуудаас илүү дуу хоолой, хайр энхрийлэл, дотно дулаан харилцаанд түшиглэсэн мэдрэмжийн шинж чанаруудаар илэрхийлэгддэг. Хүүхэд нүдээр харж буй

¹ Г.В.Ф.Гегель. Философия истории. СПб. 1993.126.

элементүүдийн хоорондын сэтгэцийн холбоог ойлгож тогтоодог бөгөөд хараахан өөртөө зорилго тавьж үйлдлээ төлөвлөдөггүй байна. Тухайлбал, 4 нас хүртлээ сам ямар зориулалттайг мэдэж эхлэх тул наана нь үйлдэл ба объектын хоорондох холбоог илүү чөлөөтэй сэтгэж түүнийг өөр зорилгоор ашигладаг. Самны оронд саваагаар самнах үйлдэл үзүүлэх гэх мэт. Харааны дүрслэх сэтгэлгээ 4-7 насанд буюу сургуулийн өмнөх насанд тогтдог. Тэгэхээр сургуулийн өмнөх насны хүүхэд харьцангуй хийсвэрлэх ойлголттой сэтгэлгээний унаган төрхийг хадгалах бөгөөд сургуульд заах нөлөөгөөр мэдлэг өргөжиж, шинжлэх ухааны үндэс суурийг эзэмших тул аажмаар тэрхүү төсөөлөл хийсвэрлэх сэтгэлгээ арилдаг байна. Дорно дахинд “авьяасыг 3-6 насанд нь олж нээ. Хүүхэд 3 нас хүртлээ гэгээнтэн, 6 нас хүртлээ суутан байдаг” гэдэг.


Харин энэхүү шинж чанарыг тээгч нь урлаг юм. “Урлаг нь ухамсартай болон ухамсаргүй үйл ажиллагааны ялгарал дээр суурилдаг” бөгөөд ухамсаргүй зөн совингийн үйл явц мэдээж зураачийн төсөөллийн ухамсарт чухал үүрэг гүйцэтгэдэг. Төсөөлөх буюу дүрслэх сэтгэлгээ өөрөө үл үзэгдэх зүйлсийн дүр төрх, тэдгээрийн харилцааг хэлбэржүүлэх боломжийг олгодог байна.

Монголчуудын уран сайхны сэтгэлгээг төлөвшүүлэх үйл явцын нэгэн жишээ бол нярай хүүхдэд үнэг хайчлан тайтгаруулдаг ёс бөгөөд дүрс, өнгө төсөөлөн тусгаж авах, нүдлэх ухааны хамгийн энгийн хэлбэр билээ. Монголчууд хүүхдэд мал зааж өгөхдөө сайн нүдлүүлж, зүслүүлдэг нь угтаа мал амьтны зан араншин, донж төрх, зүсийг андахгүй ажигч гярхай болгох хүн-амьтны харилцааны тухай анхны дадал суулгаж буй явдал юм.

Дорно дахины сэтгэлгээний нийтлэг хэв маягийн гол онцлог нь аливаа юмс үзэгдлийг бүхэл цогцоор харж, оюун сэтгэхүйг голлон баримтлагч, хүний өөрийнх нь дотоод сэтгэлийг бүтээх бясалгагч соёлоос эхтэй билээ. Үүнийг бид амьтны зан араншинг сайтар ажиглаж, сэтгэл оюундаа бүтээх жишээнүүдээс харж болно. Өөрөөр хэлбэл нүүдэлчид амьтны зан араншинг сайтар ажиглаж сэтгэл оюундаа тогтож түүнийгээ ихэвчлэн санаанаасаа ургуулан дүрслэх уран сайхны аргатай. Үүнийг өрнө дорнын онцлогоор жишиж үзвэл, өрнийн зураачид морь зурахдаа түүний хажууд суугаад бие, булчингийн хэлбэр бүрийг цаасан дээр буулгах бол дорнын зураач сайн ажигласны дараа гэртээ суугаад дотор төсөөллийн тусгаж авах чадвараа ашиглан морийг чөлөөтэй зураасаар татлах маягаар илэрхийлж зурна гэсэн үг. Дээрх жишээнээс дорно дахиныхан ерөнхий дотоод ертөнцийг илүү

ургуулан сэтгэх, өрнөдийнхөн тэргүүнд бодит нарийн хэсэг талаас сэтгэх, сэтгэлгээ хоорондын ялгааг харж болно. Нэрт зураач Ци Байши натурализмыг шүүмжлэн “амьдралыг би тэр чигээр нь хуулбарлахгүй, хуулах нь бүдүүлэг мөн адил бус байх нь ч хууран мэхлэл” гэж үздэг байсны дээр дүрслэлийн гол зүйлийг анхаарч зурдаг байжээ.

Өвгөн ноён М.Пүрэвжавын зурсан “Хошуу наадам” зураг дахь хурдан морьдын шинжээс морь-хүн хоёрын харилцаа, малын тухай гоо сайхны ойлголт, хүч, явдал, зүс, галбир, авир, хөдөлгөөнийг тодотгох дүрслэлийн онцлог хийгээд иргэний зургийн уран сайхны хөгжлийн ерөнхий нийтлэг зүй тогтлыг харж болно.



Зураг 1. М.Пүрэвжавын “Хошуу наадам” бүтээлийн хурдан морьдын шинж дүрслэл

Эртний Энэтхэгийн сургаалд заан гэж юу болохыг мэдэхийг хүссэн хараагүй хүмүүсийн тухай өгүүлдэг. Тэдний нэг зааны хөлийг барьж аваад “заан бол багана мэт” гэхэд өөр нэг нь гэдсийг тэмтэрч үзээд “заан бол лонх” гэж. Гурав дахь хүн сүүлэнд хүрч “заан бол хөлөг онгоцны олс”, дөрөв дэх нь их биеийг барьж үзээд “заан бол могой” гээд тэдний заан гэж юу болохыг ойлгох оролдлого амжилтгүй болжээ. Учир нь тэд юмс үзэгдлийн бүхэл мөн чанарыг биш, харин түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн шинж чанаруудыг мэдэх оролдлого хийсэнд байгаа юм. Үүнтэй адил бодит байдлын нэгдмэл шинж чанаруудыг ойлгоогүй урлахуйн ойлголт бол сүүлнээс өөр зүйлийг барьж чадаагүйгээс зааныг олсоор төсөөлөх сохор хүн лугаа адил юм. Өөрөөр хэлбэл өрнийн урлаг бодит байдал өнгө зүс, галбир дүрслэхийг хичээдэг бол дорнын урлагт цогцоор сэтгэх буюу хийсвэрлэх аргыг эрхэмлэж зан төрх дотоод төрхийн онцлогийг илүүтэй үздэг ажээ. Энэхүү уран дүрслэлийн сэтгэлгээний хэрэглүүр нүүдэлчдийн дүрслэх сэтгэлгээнд илүү ойр бөгөөд энд зөвхөн нүдний мэдрэхүйг ашигладаггүй. Бид төсөөллөө ашиглах ба үүнд

зөвхөн харааны төдийгүй дуу, үнэр амт, хүрэлцэхүйн мэдрэмжүүдийг төсөөлөх хэрэгтэй болдог.

Дээрхийн адил сэтгэлгээ бүхий дүрслэлийн хэллэг монголчуудын ардын зургийн хэлбэр болох загал зураг, хөзөр, үйчүүрийн зургуудад ажиглагддаг. Хэдийгээр шашин бөөгийн тэнгэр, лус савдаг, тахилын сэдэвтэй ч шашны тогтсон хэв маягт баригдалгүй хүн амьтны дотоод чанар төрхийг дүрслэх хандлага илүүтэй харагдана. Үйчүүрийн зурагт зөвхөн шувууны төрөл гэхэд бор шувуунаас хангарьд хүртэлх 64 төрлийн жигүүртэн, 32 туулай, 16 буга гэхчлэн 130-аад амьтдыг өөр хооронд нэг бүрчлэн давтамжгүй зан байдлыг гаргаж зурах нь тухайн зураачийн уран сэтгэмж, авьяас чадвараас гадна уг амьтдын шинж төрхийг танин ухаарсан мэдлэг ойлголтын тусгал юм. “Мод зурахдаа түүнийг яаж ургасныг эхлээд мэдрэх ёстой” гэх дорнын үг хэлц юмс үзэгдэл, хүн амьтны зан төрхийг гярхай ажиглаж, түүнийг таньж мэдэхийг хичээж, бодит дүрслэлээс илүү сэтгэлийн гүн чанадыг илүүтэй чухалчлах сургасан хэрэг. Энэ мэт уламжлалаас суралцаж юмс үзэгдлийн учир шалтгааныг зурж судлахын зэрэгцээгээр байгаль, хүн амьтан тэдгээрийн харилцан уялдааг ажиглаж донж төрх, зан араншинг судалж уран бүтээлдээ ашиглаж байсан жишээ олон.

Монголын их философич Агваанбалдан “Умын дуулал” буюу төв үзлийн магтаалдаа аливаа үзэгдэл нь хармагц мөн чанараа илэрхийлдэггүйд хамаг учир оршино. Харин тэдгээрийг Умын буюу төв үзлийн онолын ёсоор нарийн шинжвэл нийлбэр чанар нь мэдэгдэх юм” гээд “үзэгдэх байдал буюу эргэн тойрон харагдаж буй уул нуруу, хад хавцал бүхнийг ажиглаж шинжлээгүй байх цагт барчийж, түрчийж байх нь үнэхээр аймшигтай бөгөөд ер бишийн хүчин чадлаар буй болсон юм шиг харагдах буй заа. Үнэндээ бол үзэгдэх байдал нь хоосон чанарыг илэрхийлж үл чадна” хэмээжээ. Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны зураач А.Ламжавын зурсан үйчүүрийн зургуудаас шашны бэлгэдлийн дүрслэлээс ангид байгалийн юмс үзэгдэл, амьтны тухай зураачийн бүтээлч ажиглалтын тусгалыг харж болно. Манай ахмад зураачид “дүрийн гадаад төрхийг хөөх аваас тэдгээрийн сэтгэлийн нарийн нууцад нэвтэрч, бүрэн илэрхийлж эс чадна. Хүний сэтгэл санаа, зан ааль хүсэл эрмэлзлэлийг төсөөлөх сэтгэлгээ, зургийн уран сайхан санаа бүгд хэм тэгш зэрэгцэн оршиж байж зураг, зургийн дундаас дүр тодорч бүтээл төрдөг” хэмээн үздэг нь дээрхтэй утга адил юм.

Монголын үндэсний зургийн нэрт төлөөлөгч Б.Шарав, Цагаан Жамба нар байгалийн үзэгдэл, хүн, мал амьтны зан авир, донж хөдлөлийг дүрслэхдээ амьтдын зан авир, далд мөн чанарт нэвтэрч, түүгээр дамжуулан санааг илэрхийлэх, улмаар уламжлал ёсоор бэлгэдэл, ёгтлолын хэллэгтэй хослуулснаар “Марзан Шарав”-ын, “Цагаан Жамба”-ын гэх уран сайхны өвөрмөц аргыг бий болгожээ. Тухайлбал, Б.Шарав аж байдлын монгол зургийн бүтээлдээ уудам их газар нутаг, олон үйл явдлыг багтаан дүрслэхдээ монгол хүний сэтгэхүйд дасал болж хоногшсон хэв шинжит дүр байдал, ёж донжийг нь олсон өвөрмөц содон дүрсээр тодорхой утга санааг дамжуулан илэрхийлдэг онцлогтой.²



Зураг 2. Цагаан Жамба, Б.Шарав нарын бүтээлийн хэсэг

Эрдэнэ зуу хийдийн Цамбын болон Аюушийн сүмийн ханан дахь Лхам бурханы хангагч эрдэнэ, Баянхонгор аймгийн Галуут сумын нутаг орших Чин сүжигт Номун ханы хийдийн хангагч эрдэнийн зураг шашны агуулгатай боловч нүүдэлчдийн мал амьтны тухай мэдлэг, гоо сайхны ойлголтыг илтгэнэ. Түүнчлэн үндэсний уламжлалт тоглоом наадмын зураг, ном судрын зураг дахь зөн бэлгэдлийн санаа, уран хэтрүүлэг, ёгтлол, зүйрлэл, адилтгалын арга нь монгол зургийн уран сайхны сэтгэлгээний суурь болж байсныг ойлгож болно.

Эртний монгол сургаальд: “нүүрнээ үзэгдэх гаднын өнгө төрх хавар цагийн зэрэглээ мэт хуурамч гэлээ ч орчлон ертөнцийн мөн чанар эрдэнэт хүмүүний ухааран бодохуй аясаар алгуур уудлагдан, улам бүр мэдрэгдэж зон олны сэтгэл зүрхэнд хүргэх учир нэгэн буй” хэмээсэн нь учиртай.

Буддын урлахуй ухаан үндэс. Энэтхэг оронд дэлгэрсэн дотоод ухаан, анагаах ухаан, дууны ухаан, нотлох ухаан, урлах ухаан хэмээх оюун эрдмийн таван салбар ухааны тайлбар лавлахыг өргөн дэлгэр багтаасан “Ганжуур”, “Данжуур” их

² Баяртөр Б. Шаравын бүтээлд хоосон чанарын үзэл илрэх нь..Дүрслэх урлаг судлал шинжлэл.УБ. 2014-Х.79.

хөлгөн судрыг XVII-XVIII зуунд монгол хэлнээ хөрвүүлснээрээ буддын гүн ухааны онол, шашны номлолын утга санаа монголчуудын гоо зүйн сэтгэлгээ, уран сайхны практик үйл ажиллагаанд нэвтэрч улмаар Энэтхэг, Төвдийн бурхан зурах дэг жаяг, дүрслэлийн зарчим хэвшин тогтсон байна. Урлан бүтээхийн үндсэнд шүтээн зураг, бурхадын баримлыг хамруулан бүтээхийг эрхэмд үзэж байв. Энэтхэгийн шүтээн зургийн гол чиглэл нь бурханы биеийн дүрс, хөргийн билэг чанар, “Бурханы номлосон биеийн дүрс хөргийн хэмжээний тийн тайлбар”, Зонховын “Бурханы дүрс ба бурхадын биеийн хэмжээг тодорхой айлдагч толь” хэмээх судраар зургийн гоо сайхны билэг чанарыг илрүүлэн бие, хэл, сэтгэлийн шүтээний тэг хэмжээний үндсийг тавьж байсан нь хожим төвд, монголын шүтээн урлаачдын мөрдөн дагах сурвалж болсоор иржээ.



Зураг 3. Дорнын зураач Маруяма Окёо (1771-72), /Киото. Үндэсний орчин үеийн урлагийн музей/ Сайн ноён хан аймгийн Далай Чойнхор вангийн хошууны зураач Ламжавын Авирмэд /1884-1974/ судалбар зургууд/ эх зураг Д.Туяа

Данжуур дахь урлахуй ухааны үндсийг тавьсан мэргэд өөрсдийн бүтээлдээ урлахуй ухааны ёс үндсийг урлагийн буюу дуу, хөгжим, бүжиг, дүрслэх урлаг, уран барилга, эд хавийн (чадлын) урлаг хэмээх ангиллаар авч үзсэн болно. Тиймээс монголын эрдэмтэд “Мэргэд гарахын орон” дээж бичигтээ энэхүү ангиллыг шүтэн баримталж, урлахуй ёсны нэрийн зүйлийг тодорхойлсон байдаг.

Урлахуй ухаан (со.риг.ва) аймаг. Их таван ухааны дөрөвдөгч нь урлахуй ухаан тул монголчуудын дүрслэх урлагийн гүн ухааны уламжлалыг илтгэн харуулж байна. Данжуур дахь “Мэргэд гарахын орон” дээж бичигт биеийн урлахуйн эрдмийг бие зарлиг (хэл) сэтгэлийн шүтээнийг бүтээх, хэлний урлахуйн эрхмийг номлохуй, тэмцэхүй, туурвихуй тэргүүтнийг судлахуй, сэтгэлийн урлахуйн эрхмийг диян билгийн ид (чадал)-ийг судлах нь болой гэсэн буй. Ухааны орон бүгд урлахуй ухааны дотор багтах, урлахуй нь бие, хэл, сэтгэхүй нь өөр хоорондоо нягт шүтэлцсэн ойлголт ба эрдмийг мэдэж, итгэл явуулах үндэс болдгийн хувьд биеийн

билгийг бүтээхүй. Жишээлбэл,” нүд нь үүлгүй намрын огторгуйд оддын чуулганаар чимсэн мэт, нүүр нь алтан уулын дотор намрын хиргүй сарны гэрэл орсон адил яруу тунгалаг байх, хэл нь сэтгэлийн нэгэн эгшин төгссөн билгийг барьж, номын ёсыг дагах, сэтгэл нь мэдлэгийн, энэрэнгүйн, үйлийн эрдмийг бүтээж хамаг амьтанд нигүүлсэнгүй сэтгэл үүсгэхүй болдог” аж. Ийнхүү юм үзэгдлийг бэлгэдэн, түүгээр дамжуулан сэтгэн илэрхийлэх нь зураг урлалын чухал арга болдог байна.

Биеийн урлахуйн гол нь бурхан бүтээх, бурханы хөрөг зурах, цутгах, сийлэх зэрэг үйлүүд бөгөөд үүнийг биеийн урлахуйн эрхэм гэж үздэг. Үүнээс гадна байшин гэр барих, бөс зураг, шороон зураг, сэтгэлээр босгох хот мандал, идээ ундаа залах, хувцас чимгийн ялгаа, онгоцны заслын хүрдэн, зэрэг үйл нь урьд хийгээд өнөө цагт олон байдаг учир биеийн урлахуйн эгэл юм. Биеийн урлахуйн эрхмийн талаар Манла ба Аала сиг тэргүүтэй төвдийн мэргэдийн зохиол бүтээл болон 3 шүтээнийг бүтээх ёс 100 цогт хэмээх онолд нарийн авч үзсэн байдаг. Биеийн урлахуй нь хүний 32 лагшин, 80 шинжийн харьцаан дээр тод тунгалаг дүрслэхүй, номын биеийг урлахад мөн чанарын бие, төгс жаргалын бие, хувилгаан бие, билэг билгийн биеийн далд утгыг гоо сайхны дүрээр төгс илэрхийлэн урлах бөгөөд энэ нь урлан бүтээхүйн эрхэм болно. Биеийн урлахуй нь биеийн махбод (18) эрхтэнд шүтэлцэнэ. Иймд тэдгээрийн үйл үйлдэл нь биеийг махбодын хүчээр илэрнэ гэж үзэж байв. Харин даян, билэг хоёр бол хүний сэтгэхүйн урлахуйн эрхэм нь бөгөөд энэ нь ”амирлан оршихүй”, ”үлэмж үзэхүй” хоёр болно. Адилтгаваас их модонд салаа, навч, цэцэг хийгээд үр хийгээд тэдний гол оньс нь үндэс байдгийн адил билгүүний ёсны дээд оньс нь энэхүү амирлан ахуй, үлэмж үзэхүй болдог ажээ. Энэ нь бодит зүйлийг танин мэдэх хүний сэтгэхүйн нарийн арга бөгөөд түүнийг уран зургаар илэрхийлэн урлах нь сэтгэлийн чадвар төдийгүй уран сайхны ба гоо сайхны эрхэм мөрөөдлийн биелэл мөн болно. Эдгээрт тулгуурлан ”биеийн урлахуй эгэл”, ”хэлний урлахуйн эгэл”, сэтгэлийн урлахуйн эгэл”-ийн сурвалжуудыг гүнзгийрүүлэн тайлбарладаг.

Монголын философич Ишбалжир, Агваандандар, Агваанхайдав, Агваанбалдан нар утга зохиол, урлагийн онол сэтгэлгээний бүтээлүүддээ урлахуйн эдгээр үндэслэлийг гүнзгийрүүлэн тусгасан байдаг. Дорно дахины дүрслэх урлагийн мастер зураач, уран барималч Г.Занабазар урлан бүтээхүйн үйл ажиллагааг биет урлагаар тайлбарлаж ирсэн нь урлахуйн ухааны өвөрмөц дэвшил болон уламжлагджээ. Буддын хүмүүнлэг, бурханлаг чанарыг үзэсгэлэн төгс зохицлоор илэрхийлсэн түүний бүтээлүүд монголчуудын буддын соёлын итгэл үнэмшил, үзэл

санаанд өөрчлөлт хийж, хүний өөрийнх нь дотоод сэтгэлийг бүтээх бясалгагч соёлоос эхтэйг тод томруун харуулсныг түүний дэг сургуулийн бурхадын дүрээс харж болно.



Зураг 4. Г.Занабазарын бүтээлүүд

Монгол гэрийн сургуулийн сургалт. Уламжлалт урлахуйн сургалт нь нийгмийн хөгжлийг дагаад олон хэлбэр, хэв маягтай хөгжиж ирсэн байна. Тэгэхдээ нүүдлийн соёл, ахуйн өвөрмөц онцлогоос үүдэн гэрийн сургуулийн шавь сургалт илүү өргөн тархацтай байжээ. Монголчуудын гэрийн сургалтын давуу тал ганцаарчилсан тул сургалтын явцад анхаарал хоёрдуулах, элдэв хөндлөнгийн саад бэрхшээл үгүй багшийн хэлснийг асуух лавлах хамтран ажиллах бүрэн боломжтой байжээ. Мөн олноор анги танхимд суралцахаас илүү үр дүнтэй юм. Сайн урлахуй ухаан, бичгийн боловсролтой багшид шавилах нь шавийн оюун ухаан, авьяас чадвар эрт нээгдэж, цаашдаа шашны ба төрийн сургуульд суралцах суурь чадварыг эзэмших идэвхтэй суралцах цаг алдахгүй өөрийн хурдаар хөгжих боломж олгодог байна.

Шүтээн зургийн сургууль. XIX-XX зууны эхэн хүртэл монгол зургийн зураач нарын олонх шүтээн зургийн суурьтай сүм хийдэд шавилан суралцсан зураач нар байв. Шүтээн урлагийн урчуудыг мэргэжлийн талаар сурган боловсруулдаг хүрээний Цогчин хурлын дэргэд лавчин (уран барималч) уран зураач, сав (түвд номын дармал бичиг) бар сийлбэр, ланз, соёмбо урлагт сургадаг зургаан зүйл, мөн монгол хичээнгүй бичгийн сургууль байжээ. Жишээлбэл: зураач болох шавь модон цагаан үнсэн самбар (сашин) дээр зураач багш нь “Бурхан Шигмүний нуман мэлмий” гэдэг ганц нүд, хөмсөг зурж өгөхөд шавь нь харандаа мэт үзүүрлэсэн модон зуруулаар түүнийг олон дахин зурж, багшийн зурсантай адил болсон бол дараах нүд болон ам, хамар, чих бусад эрхтэн хэсгүүдийг зурах замаар шат ахиж, хэрвээ

буруу зурвал баллаж цагаан үнсээ түрхээд дахин зурна. Сар бүрийн 25-нд сорилт үзлэг болж дүн гаргахад хичээл даалгавар муу шавь нарыг шийтгэж, сайн сурагчид хүний бие хувцасны нугалаа, цэцэг навч, гал, ус зэрэг байгалийн үзэгдэл зурж сурсны дараа дэвсгэр даавуу цардаж, будаг найруулах, техник ажиллагаа болон бурханы тэг хэмжээ заалгаж, сурагчийн хичээл авьяасын хирээр хэдэн сар, жил болсны дараа бүрэн хэмжээний бурханы хөрөг бүтээх эрх авах зэргээр 25 жил хүртэл хугацаанд суралцаж “Гавжийн дамжаа” барьдаг байжээ. Сургуулийн төгсгөлд зориулж хийсэн зүйлээ Чогчинд очиж шалгуулдаг байсныг “дээж өргөх” гэдэг байжээ. Шалгалтаа амжилттай өгвөл сургууль төгссөнд тооцогдож, хаана, хэнд, юу ч урлах эрх, бүрэн буюу шар цоохор олбог хэрэглэх ямба, хурлаас авах боовны тоо нэмэгдүүлэх зэрэг эрх авдаг байжээ³. Тэдгээрийн жишээг бид яруу найрагч Данзанравжаагийн хүүхдийн дацанд зураг урлалын ухааныг зааж сургаж байсан тахилын зургууд, зургийн хэрэгсэл ур ухаан, мэдлэгийн хэмжүүр хийж байсан батламж мутар зэргээс харж болно.

1911 оноос улс төр нийгмийн амьдралд гарсан өөрчлөлттэй холбогдон монгол зургийн сэдэв агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, шашны бус иргэний нийгмийн амьдралыг дүрслэх хандлага аажмаар ажиглагдах болсон билээ.



Зураг 5. Данзанравжаагийн байгуулсан хүүхдийн дацан нэрт сургуульд хэрэглэж байсан урлахуй ухааны сурах бичгүүд. Сургууль төгсөгчдөд даавуун дээр дарж олгодог “Оюуны лянхуа дэлгэрсэн” хэмээх хэв, дардас

Монгол зургийн уран сайхны сургууль. Монголчуудын ертөнцийг үзэх үзлээс улбаатай гоо сайхны сэтгэлгээний хөгжлийн тод жишээ урлахуй ухаан, үндэсний зургийн бүтээлүүд бол орчин цагийн монгол зургийн уламжлал ба шинэчлэлийн суурь судлагдахуун юм. 1960-аад оны эхээр ахмад үеийн уран бүтээлчид дэлхийн сонгодог уран зургийн онолоос бүтээлчээр суралцаж үндэсний

³ Дамдинсүрэн Д. Дүрслэх урлаг.1980.1.Х.22

зургийг европ маягийн урлагийн туршлагаар хөгжүүлж өрнийн маягийг үндэсний өвөрмөц шинж, урлахуйн арга ухаантай баяжуулан хослуулах хандлага дэлгэрчээ.

1970-аад оноос монгол зургийн сургалтын арга зүйг боловсруулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх ажлууд үе шаттай эхэлжээ. 1980-аад оноос өрнөдийн орнуудад суралцаж ирсэн зураачдын нөлөөгөөр монгол зургийн сургалтад өрнийн зохиомжийн онолын үндсэн суурь ойлголт нэвтэрсэн нь монгол зураг, шүтээн зургийн ялгамжийг тодотгоход дэвшил болж, орчин үеийн дэлхийн урлагийн хэмжээнд хүртэл хөгжих боломжийг олгосон байна. Энэ тухай монгол зургийн багш Ц.Нармандах "Баухаус"-ийн сургалтыг монголын нөхцөлд уялдуулан уламжлалаа судлан суралцах шинэ заах арга зүйг боловсруулж үндэсний зургийн сургалтын цар хүрээг өргөжүүлсэн тэлж нүүдэлчдийн урлагийн сан хөмрөгөөс суралцах боломжийг бий болгосон юм" хэмээн тэмдэглэжээ.⁴ Дөчөөд жил монгол зургийн мэргэжлийн сургалт явуулж ирсэн туршлагатай Дүрслэх урлагийн сургууль үндэсний зургийн онол, практикийн ойлголтуудыг шинжлэх ухааны үндэслэлтэй судлах, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох асуудалд голлох байр суурьтай оролцож монголчуудын уран сайхны сэтгэлгээний онцлог, арга барилыг хадгалах, шинэ агуулга хэлбэрээр баяжуулан өвлүүлэхэд сургалт, судалгааны ажлыг чиглүүлж ирсэн байна.

Монгол зургийн мэргэжлийн боловсролын агуулга. Үндэсний дүрслэх урлагийн уламжлал, уран сайхны сэтгэлгээний онцлогт тулгуурлан урлан бүтээх, ур ухааны суурь мэдлэг, зохиомжлох арга ухаан, өнгө, дүрслэлийн хэллэг зохицол, дүр ба ахуйн шүтэлцээг мэргэжлийн төвшинд боловсруулах арга ажиллагааг эзэмшүүлэх, өрнө дорнын сэтгэлгээний онцлогоос бүтээлчээр суралцах, агуулга хэлбэрийн шинэчлэл хийх, уран сайхны ур ухааны дадал чадвар, сэргээн засварлах болон монгол зургийн суурь мэдлэг, бүтээн туурвих арга ухааныг сургалтын үйл ажиллагаагаар эзэмшүүлэхэд хичээлийн үндсэн агуулга оршино.

Монгол зургийн онолын суурь мэдлэг. Нүүдэлчдийн уран сайхны сэтгэлгээний эх язгуур нүүдлийн өв соёлын хүрээнд шашин шүтлэг, ёс заншил, түүх угсаатны зүй, дорно дахины арга билгийн тогтолцоо, буддын гүн ухааны танин мэдэхүй, гоо сайхны сэтгэлгээ, урлахуй ухааны онол, дэлхийн урлагийн түүх соёлын онол, гоо зүй, урлагийн сэтгэл судлал, урлагийн бүтээл задлан шинжлэл зэрэг суурь

⁴ Монгол зургийн сургалт, шинэчлэл. Монгол зураг каталог. ДУДЭС. 2005.

шинжлэх ухааны онолын мэдлэг чадварыг эзэмшүүлэх, дүрслэх урлагийн аль нэг чиглэлд дагнах, хавсран ажиллах чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэгддэг.

Дүрслэх урлагийн элемент гэж юу вэ? Дүрслэх урлагийн элемент буюу бүрдэл хэсэгт зураас, дүрс, хэлбэр, орон зай, бичилт, үнэт зүйл болон өнгө зэргийг ерөнхийд нь хамруулан ойлгож болно. Уран бүтээлч нь эдгээрийг бүтээх зарчимтай хослуулан урлагийн бүтээлийг туурвидаг. Бүтээлд бүх бүрдэл хэсэг орохгүй байж болно, гэхдээ доод тал нь заавал хоёр бүрдэл хэсэг байдаг.

Хэв маяг, Урлагийн стиль (хэв маяг), школь буюу дэг сургууль нь хөдөлгөөн, үзэгдэл болон ирсэн байдаг. Эдгээр нь юугаараа ялгаатай юм бэ? Хэв маяг гэдэг нь урлагийн бусад төрлүүдэд ч хэрэглэгдэж байдаг түгээмэл нэр томьёо бөгөөд тухайн уран бүтээлийг хийхэд ашигласан техник буюу арга барилыг ихэвчлэн нэрлэнэ. Хэв маяг нь тухайн уран бүтээлийн цаад агуулга буюу тухайн уран бүтээлчийн бүтээлээ туурвих өвөрмөц илэрхийлэл, уран бүтээлийн өнгө төрх зэргийг илтгэж болно.

Дэг сургууль. Аливаа нэг дэг сургуулийг ижил хэв маягийг баримтлагч, нэг багштай буюу нэг зорилготой бүлэг уран бүтээлчид үүсгэдэг ба эдгээр хүмүүс нэг газарт харьяалагддаг онцлогтой. Хүрээний дэг гэх мэт аль нэг газар орон буюу хотын нэрээр нэрлэгддэг байв. Тэд багшаас шавьд баримталдаг хэв маяг, дэг сургуулиа өвлүүлэн уламжлуулдаг байжээ. XVII зууны уран зураач барималч Г.Занабазарын уран сайхны дэг сургууль уран бүтээлчдийн бүтээлээр дамжин амьдарч, өнөөг хүртэл үргэлжилсээр байна.

Монгол зургийн сургалтын агуулга, арга зүйн зарим асуудалд.

Дүрслэх урлагийн сургуулийн монгол зургийн зохиомжийн хичээлийн агуулга нь талбайн зохиомжийн анхан шатны суурь мэдлэгт үндэслэн зурах аргачлалыг суулгахад оршдог. Даалгаврыг дэс дараалалтай баяжуулан хөгжүүлэх зарчмаар талбайн зохиомжийн анхан шатны өрөлт, чимэглэлийн зохиомжийн мэдлэг олгох, зохиомжийн онолын дагуу анализ, судалгаа, сэдвийн өнгө ба дүрийн боловсруулалт олон хувилбараар гүйцэтгэх, техник арга ажиллагааг судлан бүтээл хийх аргад суралцдаг. Харин ахлах курсийн мэргэжлийн зохиомжийн хичээлд дүрсийн амилаг хэллэг ба өнгийн хэллэгийг чухалчлан зохиомжийн онолын дагуу сэдвийг илэрхийлэхдээ илүү дотоод мөн чанарыг судлах бүтээлч сэтгэлгээ арга барил суулгана. Мөн сонгодог бүтээлүүдийн зохиомжийн онолын судалгаа (анализ) урлан бүтээх арга барилд гоо зүйн үүднээс дүгнэлт хийж чадварыг суулгахад чиглэгддэг.

Дүрслэх урлагийн сургуулийн хувьд монгол зургийн сургалтын онол арга зүйн асуудал үргэлж судлагдахуун байсаар ирсэн. Тухайлбал, монгол зургийн уран сайхны илэрхийлэл, зохиомжийн дэг, арга хэрэгсэлд дүрийн боловсруулалт, зураас голлох үүрэгтэй чухал асуудал юм.

Уран сайхны дүрийн тухай ойлголт. Урлагт сэтгэлгээ, уран сайхны дүр төрхөөр илэрхийлэгддэг. Уран сайхны дүрийн асуудал уран бүтээлийн салшгүй нэг орон зай бөгөөд хүний сэтгэлгээний онцгой хэлбэр төдийгүй уран сайхны сэтгэлгээний хэрэгслээр бий болдог бодит байдлын дүр төрх юм. Урлагийн бүтээлийн дүрслэлийн хүрээ уран зөгнөл, зөн совин, төсөөлөл, бүтээлч байдал зэрэг ухамсрын олон янзын төвшинд нэгэн зэрэг үүсдэг. Дүрийн тухай туршлага энэ орон зайд бүтээлч байдлаар өрнөдөг. Сэтгэл хөдлөл уран сайхны дүр төрхийг бий болгох нэг үндэс юм. “Эртний индианчууд хүн өөрийн сэтгэлд автсан мэдрэмжийг барьж дийлэхгүй үед урлаг төрдөг гэж үздэг⁵. Урлагийн уран сайхны дүрийн гол үүрэг, агуулга бол хүрээлэн буй орчинд болж буй үйл явдлуудыг дүрслэн харуулахдаа тэдгээрийн гадаад болон оюун санаа, сэтгэл зүйн шинж чанаруудыг тодотгон харуулах үүрэгтэй. В.Гүларанзын дөрвөн мөрт хос уянгад ”Өнгө чинь гурван хаврын тоорын цэцэг мэт. Үнэр чинь есөн намрын сүмэн өвс адил. Үсний хар ямагт бэхийн харыг даран чадаад. Үнэн улаан яахин түүний уруулын улааныг гүйцнэ” хэмээн хүний гоо сайхан шинжийг дүрсэлсэн шүлэглэсэн явдал уран зурагт тусган буулгавал үзэмж төгс эмэгтэйн дүрээр буух биз. Энэ нь урлахуйн туурвил зүй уран сайхан нээлтээр баялаг хүний гадаад, дотоод ертөнцийн сэтгэлийн хөдлөлийг нээн дэлгэсэн уран яруу дүр, зураглалаар дүүрэн байх ёстойг адилтгасан зүйрлэл бөгөөд дорнын урлагт оюун сэтгэхүйг голлон баримтлагч, хүний өөрийнх нь дотоод сэтгэлийг бүтээх бясалгагч соёлоос эхтэйн тод жишээ юм.

Зохиомжийн дэг дахь уран сайхны дүрийн асуудал. Монгол зургийн уран сайхны язгуур сэтгэлгээний хэлбэр уран бүтээлчийн ертөнцийг үзэх үзлийг илэрхийлэх агуулгын суурь бол уран сайхны дүрийн асуудал юм. Уран бүтээлч өөрийн үзэл санаагаа бүтээлдээ тодорхой бүрэн дүрслэх, дүрийн мөн чанарыг гүнзгий ойлгож илэрхийлэх явдал уран сайхны дүр боловсруулах үндэс болдог.

⁵ The Concept of Emotion in Classical Indian Philosophy First published Tue Mar 1, 2011; substantive revision Mon Jul 19, 2021, [Stanford Encyclopedia of Philosophy](#).

Дүрс бол сэтгэгдлийн үр дүн харин дүр бол зураачийн уран сэтгэмж уран зөгнөл түүний бодлын бүтээгдэхүүн юм. Сүүлийн жилүүдэд дүрслэх урлагийн сургуулийг төгсөгч мэргэжлийн уран бүтээлчдийн дунд өрнийн зохиомжийн дэг маягийг монгол зургийн урлахуйн арга ухаантай зөв зохистой хослуулах явдал хэдийгээр шинэчлэлийг эрэлхийлсэн явдал боловч үндэсний гоо сайхны ба уран сайхны сэтгэлгээний хэр хэмжээнд илэрхийлэх арга ухаан дутмаг зэргээс уран сайхны дүрийн боловсруулалт сул, сэтгэл хөдлөл, хөдөлгөөн үгүй хөшүүн, сэдэв агуулгын хувьд нэгнээсээ хуулбарлах, гүйцэтгэл дутуу байдал ажиглагдах болжээ. Зөвхөн ерөнхий зохиомж, өнгийн хэллэгийг чухалчлах үзэгдэл бол суурь уран зургийн зохиомжийн агуулга, өнгийн шийдэлд автах байдалд хүргэж байна.

Орчин цагийн монгол зургийн сургалтын үндэс өрнийн зохиомжийн суурь ойлголтод тулгуурлан уламжлал ба шинэ урлагийн хоорондын шүтэлцээн дээр хөгжих боломжийг эрэлхийлдэг онцлогтой. Энэхүү шинэчлэл шүтээн зураг, монгол зургийн ялгамж онцлогийг тодорхойлох сургалтыг илүү өргөн хүрээнд явуулах боломжийг олгосон боловч мэргэжлийн зохиомжийн дэг хэрэгсэлд өрнийн урлахуйн сэтгэлгээгээр боловсруулалт хийх явцад уран сайхны дүр, зураас түүний орон зайн хэллэгийг орхигдуулах явдал дээрх төгсөгчдийн жишээнээс харагдаж байна. Иймд үндэсний зургийн бакалаврын сургалтын зохиомжийн хичээлийн агуулгыг эргэн харах арга зүйн хувьд засаж залруулах, уран сайхны дүрийн судалгаа, боловсруулалтын асуудалд анхаарах шаардлага байна. Тухайлбал, Оюутан сонгосон сэдвийн дагуу зохиомжийн эрэл хайгуул хийхдээ суурь уран зургийн загвар боловсруулалтын үндсэн аргачлалд тулгуурлан гүйцэтгэдэг. Зохиомжийн онолын дагуу анализ, судалгаа (сэдэв сонголт-хүнд хөнгөн тон-өнгийн питно) гэсэн дэс дарааллаар загвар олон дахин боловсруулах шийдлээс эхэлдэг гэсэн үг.

Эдгээр гүйцэтгэлийн дараа сонгогдож батлагдсан, хүнд хөнгөн харьцаа ба өнгийн зохиомжийн загварын (эскиз) дагуу зохиомжийн хар зураг боловсруулах ажилд ордог. Хүнд хөнгөний харьцаа, өнгийн загвар дээр олон дахин хичээнгүй гүйцэтгэсэн оюутан дараагийн үе шат уруу ороход нэгэнт зохиомжийн гүйцэтгэл дуусгах хугацаа шахуу болсон байх тул зохиомжийн уран сайхны дүрийн судалгаа, хар зураг боловсруулалт гүйцэтгэл дутуу болно. Нэг үгээр хэлбэл оюутан уран сайхны дүр боловсруулах эрэл хийж чадахгүйд хүрэхүйц ачааллыг зохиомжийн хүнд хөнгөний харьцаа, өнгийн загвар боловсруулах ажлын явцад авчихсан байдаг. Сэтгэхүйн хувьд оюутан зөвхөн батлагдсан өнгийн загварт баригдаж, хар зураг,

түүний доторх уран сайхны дүр боловсруулах сэтгэл зүйн хараат байдалд ордог тул дүрийн уран сайхан илэрхийлэл, гоо сайхныг гүйцэтгэлээрээ бүрэн дүүрэн харуулж чаддаггүй байна.

Иймд зохиомжийн уран сайхны илэрхийлэл, гоо сайхныг зохион байгуулах эхлэл бол дүрийн хэллэг гэдгийг дорнын сэтгэлгээ талаас харж анхаарлаа хандуулах хэрэгтэй. Уран сайхны дүрийн боловсруулалт зохиомжийн байгуулалт хийхэд голлох үүрэгтэй тул түүнийг зохиомжийн хэвчилсэн схемчлэлд оруулах бус харин дүрийн илэрхийлэл утга агуулгад зохиомжийг захируулан хийх зэрэг сэтгэлгээний онцлогтой сургалтын арга зүйн шинэчлэлүүдийг хийх шаардлага байна.

“Бид уран сайхны дүрийн голлох мөн чанарыг тодотгож, дорнын оюун сэтгэхүйн үүднээс авч үзвэл орчин цагийн уламжлалт монгол зургийн зохиомжийн дэгд хандах бидний хандлага маань хэрхэн өөрчлөгдөх бэ? Юуны түрүүнд зохиомжийн хичээлийн дэг хэрэгсэлд урлан бүтээх дорно ба өрнийн сэтгэлгээний онцлогийг сайтар анзаарч хувь хэмжээг тохируулан хоршуулах явдал юм. Ингэснээр орчин цагийн монгол зургийн зохиомжийн дэг хэрэгслийн ялгаа, онцлогийг дорнын сэтгэлгээний үүднээс тайлбарлах боломжийг олгох юм. Үүний тулд:

- Талбайн зохиомжийн хичээлийн анхан шатны өрөлт, чимэглэлийн зохиомж хийх суурь мэдлэгтэй зэрэгцээн оюутны дүрслэлийн сэтгэлгээг хөгжүүлэх, уран дүрслэлийн анхны хэрэглүүр дүрийн хэлбэр, түүний үүргийг тодотгосон тайлбар лекц, дасгал, даалгаврыг дэс дараалалтай боловсруулах.,
- Ахлах курсийн мэргэжлийн зохиомжийн хичээлд сонгосон сэдвийн дагуу юуны түрүүнд уран сайхны дүрийн судалгаа, боловсруулалт хийх цагийг онцгойлон суулгах.,
- Нүүдэлчдийн ертөнцийг үзэх үзлээс улбаатай гоо сайхны сэтгэлгээний хөгжлийн ерөнхий нийтлэг зүй тогтол дээр суурилсан. “Монгол зураг”-ийн дүрслэлийн онцлог, уран сайхны онолыг боловсруулах.,

Энэхүү аргачлал өрнийн сэтгэлгээ бүхий зохиомжийн аргачлал бөгөөд нэгэн хэвд баригдахгүй дорнын сэтгэлгээний үүднээс дүрийн илэрхийлэл утга агуулгад зохиомжийг захируулах буюу бүтээлч ярилцлагын үндсэн дээр оюутны анхдагч зохиомжийн ерөнхий байдлыг сэтгэл оюундаа ургуулан бодох төсөөлөл, сэтгэлгээнд тулгуурлан дүрийн боловсруулалт олон янзаар хийж үзэхэд тустай.

Түүний дараа сонгогдсон уран дүрийг зохиомжийн утга дэгд таарсан хар зурагт орох бусад байгалийн үзэгдэл, эд зүйлийн дүрслэлтэй уялдуулан хэд хэдэн байрлалаар эвлүүлэн үзэж зохистой байрлуулна. Эцэст нь хүнд хөнгөн харьцаа болон өнгийн эскиз хэдэн хувилбараар үзэх гэсэн зохиомжийн дэг хэрэгслийн дарааллын тухай асуудал юм.

Бид сургалтын явцад уран сайхны дүрийн боловсруулалтад илүү ач холбогдол өгснөөр орчин цагийн монгол зургийн мэргэжлээр төгсөгчдийн уран бүтээлийн чанар чансааг сайжруулах, зохиомжийн сэдэв, төрөл зүйлийг хөгжүүлэх илүү боломжтой болно.

Дорнын урлагт гоо сайхан ба уран сайхны дүрийн илэрхийлэл байхгүй бол зохиомжийн асуудал яригдахгүй. Зураачид дүрийг бүтээлийн уран сайхны бие даасан агуулга бүхий хэсэг гэж ойлгодог. Ерөнхий утгаар уран сайхны дүр төрх бол уран сайхны илэрхийлэл, сэтгэл хөдлөлийн ач холбогдол талаас нь авсан бүтээлийн нэгэн оршин тогтнох арга зам хэмээн үздэг. Манай ахмад үеийн уран бүтээлчид, тухайлбал зураач-багш Б.Чинтогтох үндэсний зургийн сургалтад сонгосон сэдэв зохиомжийн дагуу мал амьтны хөдөлгөөн, зан төрхийг харуулсан дүрийн судалгаа олон хувилбараар хийх дадал суулгахад ач холбогдол өгч байсан туршлага бий.

Зураас буюу хөдөлгөөний асуудалд. Монгол зурагт зохиомж, дүрслэлээс гадна уран нарийн бийрний таталтын зураас онцгой үүрэгтэй. Зураас тухайн уран бүтээлчийн ур ухаан, сэтгэлгээний хандлагыг тод томруун харуулдаг. Дорнын урлагт “зураас уншиж чаддаггүй хүн зургийн урлаг ойлгохгүй хэмээн ярилцдаг. Зураасаар аливаа дүрс, бэлгэдэл, эд юмсыг дүрслэх төдийгүй эзлэхүүнийг илэрхийлэн, орон зайг бүтээж гүнийг дүрслэхийн зэрэгцээ сэтгэл хөдлөлийн нэгэн хэлбэр илэрхийлэл болдог. Монгол зургийн нарийн зураас, татлагын талаар эрдэмтэн И.И.Ломакина “Хятад төвд уран зурагтай харьцуулахад монгол зураг илүү чимэглэлтэй бас хавтгайдуу юм. Түүнд хүрээлбэр зураас онцлох үүрэг гүйцэтгэдэг юм. Ялангуяа орон зайн илэрхийлэлд чухал үүрэгтэй байдаг⁶ гэж бичжээ. Ерөөс өрнийн урлагаас ялгарах дүрслэл, илэрхийллийн нэгэн онцлог нь энэ юм. Монгол зургийн сургалтад уран сайхны дүр, зохиомжийн боловсруулалтын эрэл хайгуулын зэрэгцээ зураас буюу хөдөлгөөнийг орхигдуулахгүй байх ёстой. Монгол зургийн зураасны уран

⁶Ломакина И.И. Марзан Шарав. М.,1974 стр 56.

хөдөлгөөн, чөлөөт татлагын хэлбэр нь хатуу, уран төгс бус байвал дүр, дүрслэл хүн мал, амьтны ёгт хошин хэв шинжийн хэллэг, онцлог шинж өөрчлөгдөхөд хүргэнэ. Учир нь олон жилийн хичээл сургуулиар уран бийрний татлагыг эзэмшиж, бийрний чанга, сул даралтаар чөлөөтэй сурмаг татсан зураасаар дүрийг амилуулж, орон зай эзлэхүүнийг бий болгодог онцлогтой. Тухайлбал, Шаравын бүтээлд хүн, амьтны хэлбэр төрх зан, араншин, нас хүйс зэрэг гадаад галбир төрх төдийгүй тэдгээрийн далд мөн чанарын нарийн зааг, ялгааг тод томруун харуулахдаа оновчтой мэргэн зураасаар хураангуйлан илэрхийлсэн байдаг.

Хөдөлгөөн. Нийтлэг хэв маяг, үзэл баримтлалыг уран бүтээлдээ тусгадаг уран бүтээлчдийг хөдөлгөөн хэмээн нэрлэх ба дэг сургуулиас ялгаатай нь тэд заавал нэг газарт харьяалагдах буюу хоорондоо харилцаа холбоотой байх албагүй байдаг. Мөн дэг сургууль нь улмаар цаашид олон уран бүтээлчдэд нөлөөлдөг бол хөдөлгөөн нь тодорхой хугацаанд үргэлжлээд тухайн уран бүтээлчдийн уран бүтээлээр дуусгавар болох хандлагатай байдаг.

Энэ утгаараа хөдөлгөөнийг “үзэгдэл” хэмээн нэрлэх нь илүү оновчтой мэт. Тухайлбал бид зураач Цагаан Жамба бол тухайлсан дэг сургуулиас бие даан аливаа газарт харьяалагдахгүй бие даасан арга барилыг хөгжүүлсэн зураач гэдгээр жишээ татаж болох юм.

Дүрслэлийг тодруулахыг хэт хичээхгүй байх. Монгол зураг XIX-XX зууны эхэн үед шүтээн зургийн арга ажиллагаа, онцлогтой уялдаатай шашны урлагийн нөлөөн доор хөгжиж ирсэн. Орчин цагийн монгол зургийн сургалтын агуулга, шинэ урлагийн хоорондын шүтэлцээн дээр хөгжих боломжийг эрэлхийлдэг онцлогтой. Монгол шүтээн зураачдын эрдэм ухааны илрэл, буддын урлахуй ёсны шилдэг шүтээн зургуудын ур хийц, зураас, өнгө, бэлгэдлийн хэллэгтэй танилцаж суралцаж хуулбарлах явдал монгол зургийн сургалтын нэгэн үндэс билээ. Монгол зургийн сургалтад хэт шүтээн зургийн арга барил уруу хандах иргэний зургийн уламжлал ур ухаан, уран сэтгэлгээний уламжлалыг орхигдуулах байдал ажиглагддаг. Энэ үзэгдэл яваадаа шүтээн зураг, дүрслэх урлагийн сургуулийн монгол зургийн сургалтын ялгаа ижилсэх явдалд хүргэх тул сургалтын явцад шүтээн зургийн хэллэгийг зөв зохистой хослуулах шаардлага бий. Монгол зургийн сургалтын хувьд бага дунд дамжаанд шүтээн зургийн хэллэгтэй хуулбарлан танилцаж дадлагажиж явдал чухал. Үе үеийн нүүдэлчдийн дүрслэх урлагийн уламжлалын сангаас суралцах үед бид тэдгээр зүйлсээс хэв маяг, өнгө дүрсийн сэтгэл хөдлөл,

мэдрэхүйн таашаал авсан байдаг тул ахлах дамжаанд илүү уран бүтээлч сэтгэлгээ хөгжүүлэх, бүтээл туурвих арга барилд тулгуурлан сургалтыг явуулах нь зүйтэй юм. Буддын урлагт бурханы тэг хэмжээст зургийг бүтээгч нь түүнийг бүтээл гэхээсээ шүтээн хэмээн үзэж ямар нэг байдлаар гарын мутар үлдээдэггүй онцлогтой.

Бүтээл хийж буй оюутнуудын гаргадаг алдаануудын нэг бол дүрслэхийг оролдож байгаа зүйлийнхээ нарийн хэсгүүд болох чимэг, өмсгөл, нүдний өнгө зэрэг дээр хэт анхаарал хандуулдаг явдал. Нарийн зүйлүүдийг тодруулахыг оролдон хэт чармайх нь цаашдаа уран бүтээл хийж чадахгүйд хүргэхүйц ачааллыг сэтгэлд өгдөг. Хэдийгээр хуулбарт суралцсанаар ур чадвар суух хэрээр уран нарийн гоёмсог дүрсэлж чаддаг болох боловч нэгэн хэв маягт баригдах тогтсон дэг жаягаас гарч сэтгэх байдал хумигддаг тал бий. Аливаа байгалийн юмс үзэгдэл, дүрслэлийг хуулбарлан махчлан зурахын оронд бодит юмсыг сайтар судлах ажлыг эрхэмлэх хэрэгтэй байдаг. Иймээс зурагт суралцах үйл явцдаа бодит байдлаас зурахаас гадна санаагаар зурах авьяас чадвараа хөгжүүлэх явдал чухал. Энэ талаар буддын урлагт дүрслэх явцад бидний анхаарах дүрслэлийн хоёр тал байдаг гэж үздэг. “Нэг нь харагдах байдлаар ямар нэг зүйл дүрслэхтэй холбон хэрэглэнэ. Хоёр дахь хүчин зүйл нь бясалгах уран сэтгэмж төсөөл” бөгөөд дүрсэлж буй зүйл бодитой оршиж байгаа гэсэн уран сэтгэмж төсөөл сэтгэлийг төрүүлнэ. Бясалгах уран сэтгэмж төсөөл сэтгэлийг эхлэн бясалгаж байгаа үед маш чухал. Дүрслэлийн тодрох хувийн талаар бид санаа зовох шаардлагагүй ба хэрэв бидний өмнө бодитой байна гэж сэтгэлдээ бодож чадаж байвал энэ нь маш сайн. Бидэнд хэрэгтэй зүйл бол ердөө ямар нэгэн харагдах дүр байдал гэж болно. Бидний төвлөрөл сайжрах хэрээр нарийн хэсгүүд нь аяндаа тодорно.

Байгалийн эрдсийн будгаар зурах явдал үнэ цэнтэй урлагийн бүтээл туурвих нэгэн үндэс болох нь. Хүн төрөлхтний хөгжлийн бүхий л үеүдэд эрдэс будаг дагаж ирсэн түүхтэй. Гурван цэнхэрийн агуйн зургуудаас палеолитын сүүлчээс байгалийн өнгөт зосыг өргөн ашиглах байсан жишээг харж болно. Ашигт малтмалын эрдэс чулуулгийн пигментүүд уламжлалт монгол зургийн үндсэн түүхий эд юм. Эрдэс чулуулгийн гаралтай будгууд олон мянган жилийн турш өнгөө хадгалах шинж чанартай. Учир нь эдгээр эрдсүүд тодорхой геологийн орчинд үүсдэг бөгөөд физик, химийн тогтвортой шинж чанартай байдаг. Тиймээс эдгээр ашигт малтмалын будаг пигментээр будсан зургийн өнгө удаан хугацааны туршид өөрчлөгдөхгүй хэвээр үлддэг. Өнөөдөр монгол зургийн уран бүтээлчид өв соёлоо

сэргээж уламжлалт аргаар бэлдсэн байтуу дээр байгалийн эрдсийн пигментийг ашиглан зурах явдал нэгэн төрлийн үнэ цэнэ бүхий тансаг урлагийн бүтээл туурвих үндэс болж байна.

XVIII зууны сүүлийн хагасаас шүтээн зургийн урлал түлхүү хөгжиж эхэлсэн түүхтэй. VIII богд Жавзандамба хутагтын ивээл доор аймаг хошууд, хүрээ хийдүүдэд төвлөрсөн бурхан шүтээн урлаач нар эртний Энэтхэгийн “Гандхарын сургууль”-ийн дэг, урлахуйн онолыг баримтлан бүтээлээ туурвиж ирэхдээ нарлаг газар нутгийн онцлогоо дагаж гэрэлтсэн, эрхэмсэг өгөөмөр өнгийн зохицол будгийн ялгарал, дагнаасыг илүү дээд төвшинд гаргасан үндэсний онцлог шинж чанарыг төгөлдөржүүлж чадсан билээ. Шүтээн зурагт урлах өнгө будаг тогтсон ёс журамтай байж. Бурханыг их 32 өнгө, шим будгийн 16 өнгөөр урладаг байжээ. Монгол урчууд төрөл бүрийн өнгийн будгийг хөрш зэргэлдээ төвд орноос авахаас гадна орон нутгийн нөөц бололцоог ашиглан амьтан ургамлын гаралтай “шимийн будаг, эрдэс гаралтай “шороон будаг” эрдсийн ордуудаас олборлон бэлтгэхийн зэрэгцээ эрдэс будаг, холбогч түүний гашлах хөгцрөхөөс хамгаалах нэмэлт бодис ихтэй нарийн технологи тэдгээрийн тус бүрийн үүргийг мэдэж, тохируулж чаддаг байж.

Өнөөдөр дүрслэх урлагийн академийн монгол зургийн сургалтад тулгамдаж буй асуудал бол уламжлалт технологийг сэргээх өвлүүлэх явдал юм. Энэ нь хожуу үеийн үндэсний соёл урлагийг шашны нөлөөнөөс салгах бодлого зэргээс шалтгаалан эрт үеийн эрдэс будгийн технологийн талаар эрдэс найрлагын талаар тэмдэглэсэн судар ном хадгалагдан үлдсэнгүйтэй холбоотой. Иймд их сургуулийн хэмжээнд үндэсний уран зураг-монгол зургийн шороон будгийн технологийг баримт эх хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан судалгааны эргэлтэд оруулах, уламжлалыг өвлүүлэн сэргээн хөгжүүлэх, бакалаврын сургалтад нэвтрүүлэх шаардлага байна.

Эрдэс будгийн технологийг ашиглах үндэслэл юу бэ? Монгол үндэсний онцлогоо хадгалсан сургалтын технологийг бий болгох, уламжлалаа дахин сэргээх түүнийгээ орчин үеийн техник технологитой уялдуулах явдал юм. Түүнчлэн өнөө үед техник, технологийн хөгжил, хотжилт, даяаршлын нөлөөгөөр орчин цагийн нийтийн соёл, урлагийн урсгал чиглэл, хэв маяг хүч түрэн нэвтэрч, уламжлалт монгол зургийн арга технологи шахагдсаар байгаа нь соёл, сэтгэлгээний хувьд ихээхэн сөрөг үр дагавартай. Мөн хотжилттой зэрэгцэн түүх соёлын дурсгалт барилга байгууламжийн өнгө будаг, түүнд хадгалагдах шүтээн зургууд хүний хүчин зүйл, агаарын бохирдол зэргээс шалтгаалан эрсдэлд хүрч болзошгүй болжээ. Тиймээс

уламжлал технологийг сэргээн бий болгохтой холбоотой сургалт, судалгаа, хэрэглээний эргэлтэд оруулах, түүх соёлын дурсгалт барилга байгууламж, шүтээн зургийн бүтээлүүдийг сэргээн засварлахдаа уламжлалт аргыг судлан, хэрэгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүний тулд:

- Уламжлалыг өвлүүлэн хөгжүүлэх боломж, арга замыг юуны түрүүнд тодорхойлох.,
- Үндэсний онцлогтой урлахуйн технологийг сэргээн орчин үеийн техниктэй уялдуулсан сургалтын арга зүй боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүн болгох., (эрдэс будаг, байтуу, зүмбэр, маажингийн уламжлалт аргууд)
- Техник технологийн дэвшилтэт аргуудыг ашигласан практик суурин, хээрийн судалгаа хийх их сургууль түшиглэсэн петрографи, урлахуй материал судлал, сургалтын лаборатори байгуулах.,
- Шавь төвт сургалтад түшиглэсэн соёлын өв, уран сийлбэр, монгол зураг, сэргээн засварлах-урлахуй ухааны чиглэлээр нарийн мэргэжлийн ур чадвар, онолын мэдлэг бүхий мэргэжилтэнг бакалавр, магистрын түвшинд бэлтгэх.,
- Түүх соёлын өвийн хадгалалт хамгаалалт, сэргээн засварлах мэргэжлийн байгууллагууд, их сургууль, музей, сүм хийдийн хамтын ажиллагаа дээрх үнэт зүйлсийг хадгалан хамгаалах.,
- Соёлын аялал жуулчлалын нэгэн цогц үзүүлбэр болох зэрэг сургалт, судалгаа инновацийн олон чухал холбогдолтой. Дүрслэх урлагийн академи, их сургууль төвтэй сургалтын лабораторийн үр дүнд эрдэс будгийн уламжлалыг сэргээснээр монгол зургийн материал судлалын суурь судалгааг шинжлэх ухааны үндэслэлтэй, нийгмийн чиг баримжаатай хөгжүүлэхэд ач холбогдолтой.

Урлахуй ухаанд суралцах сэтгэлзүйн суурь. Монгол зургийн хичээл бол сурагчдын харааны мэдрэхүй, ой тогтоолт, уран сайхны сэтгэлгээ, орон зайн төсөөлөл, хийсвэрлэл, харьцуулалт зэрэг сэтгэхүйн үйл явцыг хөгжүүлдэг онцлогтой учраас суралцах үйл ажиллагаа нь суралцагчдын хувийн идэвх чармайлт, дур сонирхол, бүтээлч байдал зэрэг олон талын нэгдмэл үйл ажиллагаагаар илэрдэг.

Монгол зургийн сургалтын эхний шатанд зураасны үндсэн элемент хэлбэрүүдтэй танилцаж эхэлдэг нь юмсын шинж чанар, хэлбэр харьцааг зөв тодорхойлж сурах зорилго тавьдагтай холбоотой. Уламжлалаас мэдлэг чадвар, дадал эзэмшихийн зэрэгцээ ажиглагч гярхай, хичээнгүй нямбай, тэвчээртэй хөдөлмөрч зан байдалд суралцахыг шаарддаг бол ахлах дамжаанд эзэмшсэн дадал, мэдлэг чадвараа

гүнзгийрэх, уран сайхны дүрслэл, юмс үзэгдлийн мөн чанарыг ойлгож танин мэдэх тэдгээрт дүн шинжилгээ хийх, задлан шинжлэх нэгтгэн дүгнэх уран бүтээлч үйл ажиллагааны арга барил, дадал чадварт суралцдаг онцлогтой. Бага курсийн оюутнуудад уламжлалт шүтээн урлал болон иргэний зургуудаас хүн амьтан, байгалийн дүрслэлийг хэсэгчлэн зурах, дүрсийн харьцаа хэмжээ, орон зайг зөв дүрслэх дасгалууд голлон олон дахин давтаж хийсний үр дүнд мэдлэг чадвар сайжирдаг.

Харааны идэвхгүй үйл ажиллагаа, үзсэн харснаа ой тойндоо тогтоодоггүй, ургуулан боддоггүй байдлыг засахад хамгийн түрүүнд анхаарлаа төвлөрүүлж сурах дадлыг эзэмших нь чухал юм. Нүдний ур буюу харааны сэрлийн төлөвшилт зүгшрүүлэлтийн арга болох хэлбэр дүрсийг олон дахин хуулбарлах, бийрний таталт, зураасны дасгал бол хэмжээ, харьцааны баримжаа дээшлүүлж гарын ур чадварыг сайжруулдаг. Энэхүү дадлага ажлын явцад хэлбэр талаас өнгөц хандаж хуулбарлах, дүрсийн мөн чанарыг анхааралгүйгээр зөвхөн адил төстэй зурах хандлага ажиглагддаг. Иймд хувь хүний танин мэдэхүйн онцлогт тулгуурлан тухайн хэлбэр дүрсийн зүй тогтол онцлог зэргийг гүнзгий судлуулах явдал сургалтын явцад хүний сэтгэцийн чанар, танин мэдэхүйн хүрээ тэлж дүрслэх арга барил, дадал чадвар төлөвшдөг.

Ажиглах чадвар. Дүрслэх үйл ажиллагааны онцлог бол суралцаж буй хэлбэр дүрсийн мөн чанарыг ойлгож зөв зурах явдал юм. Ажиглах чадвараа хөгжүүлэхийн тулд зурж буй дүрсийн хэлбэр дүрсийг бүхэлд нь харж сурахын зэрэгцээ юуны тулд яаж гэж хуулбарлаж, зураасны дасгал хийж байна вэ? гэдэг асуултыг өөртөө тавьж төлөвлөгөө зорилготой ажиглах чадварыг эзэмших хэрэгтэй. Хүн амьтан, байгалийн хэлбэр дүрсийг хуулбарлахдаа гадаад хэлбэр төрх байдлыг үнэн зөв хуулбарлахаас гадна хүн амьтны хөдөлгөөн, зан ааш, донж төрхийг гаргасан онцлог шинжүүдийг анзаарч тэмдэглэж байх нь бүтээлч уран чадвар суух үндэс юм. Дүрийн боловсруулалт уран сэтгэмж, зохиомж техник ажлын гүйцэтгэл бол монгол зургийн уран сайхны илэрхийллийн арга хэрэгсэл төдийгүй ур чадварыг илтгэх нэгэн чухал хэмжүүр юм.

Бүтээхүйд хандах сэтгэлийн хандлага. Эртдээ их хүрээний Лун ван (шүтээн бүтээх) авшиг эрх авсан шүтээн урлаач нар зураг бүтээхийн өмнө бясалгал хийж гурван цагаан, амттаныг хэрэглэж хоол ундандаа цээр тавьж байж. Сонгино сармистай хилэнцтэй идээ амьтны гаралтай хоол барихыг хориглож, архи, тамхи,

садар самуун гурван хороос хол байхыг эрхэмлэдэг байж. Мөн зургийн тэлүүрийг өт хорхойд идэгдээгүй өтөлж хөгшрөөгүй үртэй жимстэй чиг шулуун модоор хийх ёстой хэмээн үзэх тул уул уснаас өвчин, үхэл зовлонгүй, эрүүл саруул хүнээр лус савдаг тахил өргүүлж гуйж авах ёс байжээ. Эдгээр ёс угтаа бүтээлдээ илүү их анхаарлаа төвлөрүүлэх, урлан бүтээхэд сэтгэл санаагаа цэгцлэх үндэс болно. Нөгөө талаас энэ нь урлан бүтээх үйлээ хүндэтгэх дээдлэх үзэл төлөвшүүлдэг байжээ. Өнөө цагт энэхүү эртний сэтгэл заслын ёс уламжлал, урлахуй хаанд суралцагч шинэ цагийн оюутнуудад ч эмх цэгцтэй байхын ач холбогдлоо алдаагүй байна. Их дээд сургуулийн хэмжээнд монгол зургийн мэргэжлийн зохиомжийн хичээл, уламжлалаас хуулбарлах мэргэшсэн ажлуудад дэс дараалалтай төлөвлөгөөтэй, нарийн нямбай байдалд суралцах, дадлагажих, оюутан өөрийн сэтгэл санааг бэлтгэх, цаг хугацааг төлөвлөхөд тодорхой сэтгэл зүйн бэлтгэлд суралцах нь зүйтэй юм.

Шинэ үеийн дүрслэх урлагийн академи ба сэтгэлгээний сургууль. Хүн төрөлхтний соёлын ертөнцөд суралцагсдын сэтгэн бодох, хувийн мэдлэгийг хөгжүүлэх, үр бүтээлтэй үйл ажиллагаа явуулах, өөрийн уран бүтээлийн замналыг бий болгох чадварыг хэр зэрэг бүрдүүлсэн бэ? гэдэг шалгуур урлагийн академийн боловсролын гол асуудал юм.

Бүтээлч сэтгэлгээ. Бүтээлч байдал нь аливаа хүмүүжлийн зорилго бөгөөд энэ нь сэтгэлийн эрүүл мэнд оюуны болон урлагийн үйл ажиллагааны хамгийн дээд төвшний үзүүлэлт юм. Бүтээлч хүмүүс бие даасан өөртөө итгэлтэй дарангуйлал, хязгаарлалтыг эсэргүүцдэг нээлттэй сониуч, мэдрэмжтэй сэтгэлгээний хувьд баялаг төсөөлөл, уян хатан байдал, өвөрмөц байдлаараа ялгардаг. Эдгээр шинж чанарууд нь ямар нэгэн байдлаар хүн нэг бүрд байдаг. Гэвч хүн бүр түүнийг ухамсарлаж чаддаггүй. Эдгээр хандлага нь дадал зуршил, ерөөсгөл ойлголт, бүтэлгүйтэх эсвэл нийгэмд хүлээн зөвшөөрөгдөхгүй байх айдас дор нуугдаж байдаг. Тиймээс орчин үеийн урлагийн академи энэхүү зөрчилдөөнийг арилгах ёстой. Оюутан бүрд өөрийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, авьяас чадавхыг нэмэгдүүлэх боломжийг олгох сургалтын арга зүйг нэвтрүүлэх, мэдлэг авах нөхцөлийг бүрдүүлэх явдал чухал юм.

Бүтээлч сэтгэлгээний мөн чанар. Бид ихэвчлэн нэгдмэл сэтгэлгээгээр (өөрөөр хэлбэл ижил төстэй, мэдлэгтэй ойролцоо) оюутнуудаа үнэлэх хандлагатай байдаг. Тухайн чиглэлээрээ мэдлэгтэй дуулгавартай багшийн хэлсэн үгийг яг таг давтдаг сурагч илүү их хайрыг эдэлдэг. Бид үүнийг ихэвчлэн авьяастай гэж нэрлэх

хандлагатай байдаг (хэдийгээр бид чадварын тухай ярьж байгаа ч гэсэн). Бүтээлч оюутан маш их “шаардлагагүй” асуулт асуудаг тул сахилга батыг ихэвчлэн зөрчдөг. Бүтээлч зан чанар гэдэг нь хил хязгаарыг зөрчих гэсэн үг биш, харин өдөр бүр өөрийн хил хязгаарыг мэдэрч түүнийг шинэ хувилбараар өргөжүүлэх зоригийг хэлнэ. Бүтээлч зан байдал нь өөрсдийгөө болон эргэн тойрныхоо ертөнцийг цаг ямагт шинэлэг байдлаар таньж мэдэхэд тусалдаг. Гэхдээ аливаа хүнд, ялангуяа оюутан бүтээлч чадвараа харуулахын тулд урьдчилсан хоёр нөхцөл шаардлагатай. Эрх чөлөө, өөртөө итгэх итгэл. Оюутан өөрийгөө байгаагаар нь хүлээн зөвшөөрч өөртөө итгэх итгэлээ алдалгүйгээр өөрийн авьяас билгийг чөлөөтэй ашиглаж чадна гэдгээ мэдрэх ёстой. Үүнд урлан хариуцсан зураач багшийн мэдрэмж чухал. Бүтээлч байдал ба авьяаслаг гэсэн хоёр ойлголтыг бид салгах ёстой. Авьяаслаг оюутнууд бүгд бүтээлч байдаггүй гэдгийг мэдэх нь чухал юм. Авьяас чадвар бол зүгээр л боломж. Олон авьяаслаг оюутнууд хүссэн үр дүндээ амархан хүрч, цааш явах урам зоригийг олж хардаггүй тул боломжит цаашдын хувилбаруудыг хэрэгжүүлэх гэж оролддоггүй. Тиймээс чадвараа ашиглаагүй тохиолдолд шилдэг оюутан дунд шат уруу унадаг. Энэ үзэгдэл ахлах дунд курст илт ажиглагдах бөгөөд мэргэжсэн лицейд бэлтгэгдсэн авьяас чадвартай гэх оюутнууд маань дамжаа дээшлэх тусам бүтээлч байдлаар тэргүүлэх оюутнуудад гүйцэгдэх хандлагаас харагдана.

V. ДҮГНЭЛТ

“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн хүрээнд суурь судалгааны арга зүй, календарчилсан төлөвлөгөө боловсруулан батлуулж, тус арга зүй, төлөвлөгөөний дагуу дараахь үндсэн гол ажлыг гүйцэтгэж “Төслийн үр дүнгийн даалгавар” (хавсралт 2)-т жагсаасан үр дүнд хүрлээ.

Үүнд: тус төсөлд үндсэн болон гэрээт хэлбэрээр оролцогчидтой ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулан, судалгаанд холбогдох материал, эх хэрэглэгдэхүүн цуглуулан боловсруулж, үр дүнг эрдэм шинжилгээний ганц сэдэвт бүтээл, илтгэл, өгүүлэл, сургалтын зөвлөмж хэлбэрээр бичиж заримыг хэвлүүлэв. Тухайлбал, “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” (УБ., 2019), “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” (УБ., 2021) зэрэг эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхтгэл, “Монгол бэхэн зураг” (УБ., 2019) ном хэвлүүлж, монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар, зөвлөмж боловсруулж, “ХХ зууны монгол зураг” номын эх бэлтгэлээ. Түүнчилэн тус төслийн

үндсэн болон гэрээт гүйцэтгэгчид суурь судалгааны үр дүнгээр магистрын зэрэг горилсон бүтээл 5-ыг бичиж, судалгааны илтгэл, өгүүлэл 20-ийг хэвлүүлэв.

Нэг. “XX зууны монгол зураг” судалгааны бүтээлд:

1. Монголын үндэсний язгуур зураг дүрслэлийн үүсэл хөгжил, төрөл зүйл, уран сайхны сэтгэлгээний хэв маяг, монгол хүний байгаль, нийгмийн тухай үзэл төсөөллийг анхааран авч үзлээ.

2. XIX зууны сүүлч, XX зууны эхэн буюу Богд хаант Монгол улсын үед бүтээгдсэн монгол зургийн гол дурсгалууд, Хүрээ хийд, хот суурины зураг, Цагаан Жамба, Б.Шарав нарын бүтээлд тулгуурлан уламжлалт монгол зураг дахь байгаль, хүн, мал, амьтны дүр дүрслэлийн хэв маяг, адилтгал, зүйрлэл, ёгтлолын сэтгэлгээ, өнгө зохиомж, дүрс, зураасны онцлог тэргүүтэнг судлан тодруулахыг хичээсэн болно.

3. БНМАУ-ын төр, засгийн газрын зүгээс дүрслэх урлагийн талаар баримталсан бодлого, монгол зургийн мэргэжлийн сургалт, түүний үр дүнд үүсэн дэлгэрсэн “монгол зураг”-ийн шинэ хэв маяг, сэдэв, агуулгыг Д.Дамдинсүрэн, Ү.Ядамсүрэн, А.Сэнгэцохио нарын бүтээлд үндэслэн тодорхойлов.

4. XX зууны сүүлч буюу 1990-ээд оны үеийн монгол зургийн сэдэв, агуулга, төрөл зүйл, уран сайхны дүрслэл, илэрхийлэлийн онцлог юу байв, түүнд чухам ямар хүчин зүйл хэрхэн нөлөөлсөн болохыг холбогдох зураач, урчуудын гол бүтээл туурвил, эрдэмтэд, судлаачдын зохиолд тулгуурлан тодруулж, монгол зургийн хөгжлийн чиг хандлагын талаар үнэлэлт дүгнэлт өгч, санал дэвшүүлэв.

Хоёр. Төслийн үндсэн гүйцэтгэгч Г.Амарсанаа монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар, зөвлөмж боловсруулж, доктор С.Бадрал монгол зургийн сургалтанд гарын авлага болгон ашиглаж болох “Монгол бэхэн зураг” (УБ., 2019) ном хэвлүүллээ.

Гурав. “Дүрслэх урлагийн академи” дээд сургуулийн магистрант О.Цацрал “Монгол зурагт эмэгтэйчүүдийг дүрслэх нь” (2018), Б.Хөхяргүй “Монгол зураг дахь натюрмортын дүрслэлийн зарим онцлог” (2019), А.Цэцэгмаа “Монгол зураг, бэхэн зургийн арга техникийг харьцуулан судлах нь” (2020), С.Хулан “Монгол зурагт ан амьтдыг дүрслэх нь” (2020), Б.Батцэцэг “Уламжлалт монгол зураг дахь амьтны дүр дүрслэлийн зарим онцлог” (2020) сэдвээр магистрын зэрэг горилсон бүтээл бичиж төгслөө.

Дөрөв. Төслийн хүрээнд “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулж, монголын зураач, урчууд, бурханч нарыг сурган бэлтгэж байсан уламжлал хийгээд монгол зургийн мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн цагаас өнөө хүртэлх үед хамрагдах монгол зургийн сургалтын бодлого, хөтөлбөр, заах арга барилыг харьцуулан судалж, санал, дүгнэлт дэвшүүлсэн 12 илтгэлийг сонсож хэлэлцлээ.

Тав. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурал цахимаар зохион байгуулж, монгол зургийн үүсэл хөгжил, монгол зургийн төрөл зүйл (ном судрын чимэг зураг, Перс-Монгол миниатюр зураг), монгол зургийн нэрт төлөөлөгч Д.Дамдинсүрэн, Б.Чинтогтох нарын амьдрал, түүх намтар, тэдгээрийн гол бүтээл туурвил, уламжлалт болон орчин үеийн монгол зургийн уран сайхны дүр дүрслэл, утга бэлгэдэл, зурж гүйцэтгэх арга ухаан, монгол зургийн хувьсал өөрчлөлт, цаашдын чиг хандлагын талаар шинэлэг санаа таамаглал дэвшүүлж, үнэлэлт дүгнэлт өгсөн 10-аад илтгэлийг сонсож хэлэлцлээ.

“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” суурь судалгааны төслийн үр дүн нь монгол зургийн мэргэжлийн сургалт, судалгааг хөгжүүлэхэд хувь нэмэр болох төдийгүй монгол зураг судлалын шинжлэх ухааны мэдлэг, онол арга зүй хөгжиж, урлаг судлаачид, багш нар, ахисан түвшний оюутны судалгааны дадлага туршлага өсөх үндэс суурь тавигдлаа гэж үзэж байна.

**ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БИЧСЭН СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ ГАНЦ
СЭДЭВТ ЗОХИОЛ, СУРГАЛТЫН ЗӨВЛӨМЖ, ЭРДЭМ ШИНЖЛГЭЭНИЙ ХУРЛЫН
ИЛТГЭЛИЙН ЭМХЭТГЭЛ, ИЛТГЭЛ, ӨГҮҮЛЛИЙН ЖАГСААЛТ**

А. Эрдэм шинжилгээний ганц сэдэвт бүтээл 1

1. Баяртөр Б. “XX зууны монгол зураг”. УБ., 2022 (хэвлэлийн эх)

Б. Сургалтын зөвлөмж, гарын авлага 2

1. Амарсанаа Г. “Монгол зургийн сургалтын зөвлөмж”. УБ., 2022 (хэвлэлийн эх)

2. Бадрал С. “Монгол бэхэн зураг”. УБ., 2019

В. Эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл 2

1. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал”. УБ., 2019

2. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага”. УБ., 2021

Г. Магистрын зэрэг горилсон бүтээл 5

1. Батцэцэг Б. “Уламжлалт монгол зураг дахь амьтны дүр дүрслэлийн зарим онцлог”. Магистрын зэрэг горилсон зохиол. УБ., 2020

2. Хөхяргуй Б. “Монгол зураг дахь натюрмортын дүрслэлийн зарим онцлог”. Магистрын зэрэг горилсон зохиол. УБ., 2019

3. Хулан С. “Монгол зурагт ан амьтдыг дүрслэх нь”. Магистрын зэрэг горилсон зохиол. УБ., 2020

4. Цацрал О. “Монгол зурагт эмэгтэйчүүдийг дүрслэх нь”. Магистрын зэрэг горилсон зохиол. УБ., 2018

5. Цэцэгмаа А. “Монгол зураг, бэхэн зургийн арга техникийг харьцуулан судлах нь”. Магистрын зэрэг горилсон зохиол. УБ., 2020

Д. Судалгаа шинжилгээний илтгэл, өгүүлэл 20

Гадаад 1

1. Баяртур Б. “Влияние советского искусства на монгольскую живопись”. Международная научно-практическая конференция. “Изобразительное искусство, дизайн и архитектура Монголии и Сибири XX – н. XXI вв: основные тенденции и кросскультурные взаимодействия”. 8 – 10 октября 2018 года, г. Улан-Батор. “Улирал ба зохиолч” сэтгүүл. 2018. №04 (20) Өвөл. 108-112-р хуудас

Дотоод. 19

1. Амарсанаа Г. “Цагаан Жамбын туурвил зүйн өв уламжлал, шинэчлэл, сургалт, судалгааны түүхэн үндэс мөн”. Монголын соёл урлаг судлал” эрдэм шинжилгээний бичиг. Боть XXXIII. УБ., 2019. 142-154р хуудас, “Улирал ба зохиолч” сэтгүүл. УБ., 2019. №02. 124-136-р хуудас
2. Амарсанаа Г. “Баруун Азийн дүрслэх урлаг дахь Ил хаадын монгол реализм. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2021. 53-72-р хуудас.
3. Амарсанаа Г. “Б.Шаравын нэрэмжит шагналт зураач Б.Чинтогтохын уран бүтээлийн онцлог”. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2021. 89-109-р хуудас.
4. Амарсанаа Г., Уранчимэг Д. “Үндэсний урлахуй ухаан, эрдэс будгийн технологийг сургалт, судалгааны хэрэглэгдэхүүн болгох нь”. “Монголын соёл урлаг судлал” эрдэм шинжилгээний бичиг. Боть XLI. УБ., 2021. 113-125-р хуудас
5. Бадрал С. “Монгол бэхэн зургийн баялаг уламжлалаас суралцаж хөгжүүлье”. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2019. 18-24-р хуудас
6. Бадрал С. “Автай сайн хааны хөрөг зургууд дахь дээлийн энгэрийн онцлог”. “Монголын дүрслэх урлаг, дизайны хөгжил” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2020. 30-36-р хуудас
7. Батзориг М. “Монгол зургийн шинэ хандлага, шинэ боломж”. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2021. 73-84-р хуудас
8. Батцэцэг Б., Баяртөр Б. “Уламжлалт монгол зураг дахь амьтны дүр дүрслэлийн зарим онцлог”. “Монголын соёл, урлаг судлал” эрдэм шинжилгээний бичиг. Боть XXV. УБ., 2018. 75-80-р хуудас
9. Баяртөр Б. “Чингис хааны хөрөг дүр монгол зурагт”. “Монголчуудын соёлын ертөнц: өв, үнэт зүйл, урлаг” Олон улсын монголч эрдэмтний хурал. УБ. 2018.7.23-25. “Монголын соёл урлаг судлал” эрдэм шинжилгээний бичиг. Боть XXIX. УБ., 2018. 94-102-р хуудас
10. Баяртөр Б. “Монгол зургийн сургалт: уламжлал, орчин үе”. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл.

УБ., 2019. 9-17-р хуудас, “Улирал ба зохиолч” сэтгүүл. 2019. №04 (24) Өвөл. 92-102-р хуудас

11. Баяртөр Б. “Монгол зургийн хөгжилд Ардын зураач А.Сэнгэцохиогийн оруулсан хувь нэмэр”. “Улирал ба зохиолч” сэтгүүл. 2019. №01 (21) Хавар. 108-114-р хуудас

12. Баяртөр Б. “1990-ээд оны Монгол зураг”. “Монголын дүрслэх урлаг, дизайны хөгжил” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2020. 9-19-р хуудас

13. Даваасүрэн Д. “Зурагт гар бичмэлийн зураг дүрслэлийн тухай”. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2021. 26-42-р хуудас

14. Молонжамц М. “Монгол зургийн бүтээлд зураасаар орон зайг илэрхийлэх онцлог”. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2021. 85-88-р хуудас

15. Мэндсайхан П. “Монголын бурхан зургийн дэг сургууль”. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2019. 78-87-р хуудас

16. Сэргэлэн Н. “Монгол зургийн сургалтын зарим асуудал”. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2019. 51-57-р хуудас

17. Цэцэгмаа А., Амарсанаа Г. “Өвөр монголын зураачдын бэхэн зураг дахь монгол ахуйн дүр дүрслэл, онцлог”. “Монголын соёл, урлаг судлал” эрдэм шинжилгээний бичиг. Боть XXXII. УБ., 2019. 84-88-р хуудас

18. Цэцэгмаа А., Баяртөр Б. “ГҮНБИ зургийн уран сайхны дүрслэлийн онцлог”. “Монголын соёл, урлаг судлал” эрдэм шинжилгээний бичиг. Боть XXXIV. УБ., 2019. 199-204-р хуудас


19. Эрдэнэцог Ц. “Ил хаант Улсын үеийн Перс-Ираны миниатюр зургийн онцлог”. “Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл. УБ., 2021. 9-17-р хуудас

“Монгол зургийн хувьсал, хөгжлийн судалгаа” нэртэй суурь судалгааны төсөл хэрэгжүүлэх, санхүүжүүлэх 2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн дугаар гэрээний 1 дүгээр хавсралт

ТӨСЛИЙН ҮР ДҮНГИЙН ДААЛГАВАР
/Техникийн даалгавар/

№	Төслөөр бий болох үр дүн	Тоо хэмжээ	Үр дүнгийн үзүүлэлт	Үр дүнг хүлээлгэн өгөх хугацаа (он, сар)
1	“Монгол зургийн хувьсал, өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж Монгол зургийн дүрслэн илэрхийлэх арга ухаан хэрхэн хувьсан өөрчлөгдөж байгааг судлан тогтооно	5-7х.х	Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл	2020.12 сар
2	“ХХ зууны монгол зураг” нэг сэдэвт бүтээл туурвиж сургалт, судалгааны орчинд нэвтрүүлнэ	10-15х.х	Нэг сэдэвт бүтээл	2020.12 сар
3	“Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал” сэдвээр эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж Монгол зургийн уламжлалт арга ухаан, технологийг хойч үед өвлүүлэх сургалтын загвар зөвлөмж боловсруулна	5-7х.х	Эрдэм шинжилгээний бага хурлын эмхэтгэл, сургалтын загвар зөвлөмж	2020.12 сар
4	Эцсийн тайлан боловсруулж, үр дүнг нэгтгэн хүлээлгэн өгөх	1	Эцсийн тайлан	2020.12 сард багтаана


Захиалагчийг төлөөлж:



Д.Одгэрэл

БСШУСЯ-ны ШУТБГ-ын дарга
1116126429 - УХА0148
9116621


Санхүүжүүлэгчийг төлөөлж:



Д.Энхжаргал

ШУТСангийн Захирал

Гүйцэтгэгчийг төлөөлж:




Д.Уранчимэг

ПУРСГАХ, ДИЗАЙН УРЛАГИЙН СУРГУУЛЬ

СУИС-ийн ДДУС-ийн захирал

Төслийн удирдагч:



Б.Баяртөр

ДДУС-ийн ЭНБД

1-р зураг. Төслийн үр дүнгийн даалгавар




2-р зураг. Танка зургийн сургуулиуд. Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс. Катманду хот




3-р зураг. Танка зургийн сургуулийн оюутнууд хичээл дээрээ. Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Балба Улс. Катманду хот







**4-р зураг. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал”
Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл**



**5-р зураг.
“Монгол зургийн хувьсал өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага” Эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхтгэл**



6-р зураг.
С.Бадрал. Монгол
бэхэн зураг



7-р зураг. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал”
Эрдэм шинжилгээний хурлын урилга, хөтөлбөр



**8-р зураг. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал”
Эрдэм шинжилгээний хурлын үйл явц**



**9-р зураг. “Монгол зургийн сургалт, тулгамдсан асуудал”
Эрдэм шинжилгээний хурлын үйл явц**

